

**ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2019 ОНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар хот

2019 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр

НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ ҮР ДҮН

1.1 “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

Хан-Уул дүүргээс хариуцан хэрэгжүүлэх нийслэл, дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, нийслэл, эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” бодлогын баримт бичигтэй уялдуулан Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуульд нийцүүлэн боловсруулж хэрэгжилтийг хангуулан ажиллаж байна.

1.2 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан нийслэлд хэрэгжих зорилтын хүрээнд тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнөөс дүүрэгт хамаарах 24 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 34 арга хэмжээний биелэлтийг тооцон 2019 оны 06 сарын 05-ны нийслэлийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. Эхний хагас жилийн байдлаар 59.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Жилийн эцсийн биелэлтийг 2019 оны 01 сарын 05-ны өдрийн дотор хүргүүлэхээр бэлтгэж байна.


Монгол улсын эдийн засаг нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлээс дүүрэгт хамаарах 2 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 5 арга хэмжээний хэрэгжилтийг тооцож 2019 оны 05 сарын 23-ны өдөр НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хүргүүлсэн. Эхний хагас жилийн байдлаар 44 хувийн гүйцэтгэлтэй байна. Жилийн эцсийн биелэлтийг 2019 оны 01 сарын 05-ны өдрийн дотор хүргүүлэхээр бэлтгэж байна.

Засгийн газрын гишүүд, салбарын сайд нартай байгуулсан санамж бичиг, хамтран ажиллах гэрээ, түүний хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

Засгийн Газрын гишүүд, салбарын сайд нартай байгуулсан санамж бичиг, хамтран ажиллах гэрээний 2018 оны хэрэгжилтийн тайланг холбогдох хэлтэс, албадаас хүлээн авч, нэгтгэн 3-р сарын 11-ний өдрийн 06/411 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Түүнчлэн 2019 онд Хан-Уул дүүрэгт хэрэгжиж буй үндэсний болон дэд хөтөлбөрүүд, санамж бичгүүдийн 2019 оны хэрэгжилтийн тайлан ирүүлэх тухай 06/2168, 06/2197 дугаар албан бичгүүдийг хэлтэс, албадад хүргүүлж, биелэлтийг хүлээн авч хяналт шинжилгээ хийлээ.

1.3 Улсын болон нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

Хан-Уул дүүргийн хэмжээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 51.4 тэрбум төгрөгийн 41 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаа бөгөөд он дамжин хэрэгжиж буй 17, шинээр хэрэгжих 24 төсөл арга хэмжээ, Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 12.4 тэрбум төгрөгийн 70 төсөл, арга хэмжээ, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2.3 тэрбум төгрөгийн 33 төсөл арга хэмжээ, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3.8 тэрбум төгрөгийн 30 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаа бөгөөд он дамжин хэрэгжиж буй 4, шинээр хэрэгжих 30 төсөл арга хэмжээ байна. Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 651.8 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ хэрэгжиж байгаа бөгөөд он дамжин хэрэгжиж буй 2, шинээр хэрэгжих 2 төсөл арга хэмжээ байна. Нийт улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр 70.5 тэрбум төгрөгийн 176 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна.



1.1.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/188, А/256 дугаар захирамжаар улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 10,373.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 7 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх дүүргийн Засаг даргад шилжин ирсэн. Үүнд:

№	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Санхүүжилт		Хороо	Ажлын явц
		2019	2020		
Тендер зарласан-3					
1	Сургуулийн спорт талбай /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 60 дугаар сургууль/	483.0	483.0	7	2019 оны 05 сарын 01-нд тендер зарлагдсан. 06 сарын 03-нд нээлт хийсэн. Үнэлгээ хийгдэж байна.

2	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 189 дүгээр цэцэрлэг/	1,800.0	900.0	6	НХОГ-аас нэг маягийн зураг төсөв хүлээн авч ХААА-нд хүлээлгэн өгсөн. 06 дугаар сарын 03-ны өдөр төндөр зарлагдсан. 07 дугаар сарын 03-ны өдөр нээлт хийнэ.
3	Цэцэрлэгийн өргөтгөлийн барилга, 280 ор /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 12 дугаар цэцэрлэг/	2,360.0	2,360.0	4	БСШУСЯ-наас магадлал хийгдсэн зураг, төсвийг хүлээн авсан. Төсөвт өртөг батлагдсан төсвөөс хэтэрсэн тул холбогдох байгууллагатай зөвшилцөн зураг төсөвт өөрчлөлт оруулан 06 дугаар сарын 12-ны өдөр төндөр зарлагдсан.
ХААА-нд хүлээлгэн өгсөн-1					
4	4 хороонд жишиг гудамж байгуулах ажил				Төндөрийн баримт бичиг боловсруулагдаж байна.
НХБХГ-аас Архитектур төлөвлөлтийн даалгавар хүлээгдэж буй-1					
5	Яармаг худалдааны төвийн өргөтгөлийн барилга	400.0	400.0	5	НХБХГ-т 2019.04.11-ны өдөр 06/680 тоотойр АТДаалгавар хүссэн албан бичиг хүргүүлсэн. Мэргэжлийн зөвлөлийн хурал болох хүлээгдэж байна.
Газрын асуудал, зураг төсөв, техникийн тодорхойлолт хүлээгдэж буй-3					
6	Зайсан орчмын хотхонуудын усан хангамжийн төвлөрсөн систем /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	4,000.0	2,000.0	11	БХБЯ-ны Хөрөнгө оруулалтын газраас зураг төсөв хүлээн авсан. Зураг төсөв магадлал хийгдээгүй тул холбогдох засварыг хийн Барилгын хөгжлийн төвд өгөхөөр ажиллаж байна.
7	Сургуулийн талбайн гадна талд цэцэрлэгт хүрээлэн /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг, 5, 6 дугаар хорооны нутаг дэвсгэр, 41 дүгээр сургуулийн урд/	680.0	680.0	5,6	Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт төсөл хэрэгжүүлэх газрын талаар тодруулга авах албан бичиг хүргүүлсэн. НЗДТГ-ын ХЭЗХ-ээс “Эс Си Эм” ХХК-д эзэмшүүлсэн 44758 м2, 38393 м2 газрыг Газрын тухай хуулийн 40.1.6-д заасан үндэслэлээр НЗД-ын 2018 оны А/792 дугаах захирамжаар хүчингүй болгосон бөгөөд одоогоор захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явагдаж байгаа гэсэн хариу ирүүлсэн.

8	Төрийн өмчит сургуулийн хүүхэд хамгаалал, аюулгүй байдлын Сүүл Алерт үйлчилгээ /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	650.0	650.0	-	Зөвлөх үйлчилгээний техникийн тодорхойлолт боловсруулах ажил хийгдэж байна.
Нийт		10,373.0	7,473.0		

1.1.2 Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/376, А/529, А/681 дүгээр захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 4 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх дүүргийн Засаг даргад шилжин ирсэн. Үүнээс Нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайд явган хүний зам шинээр тавих, засварлах ажлын гүйцэтгэгчээр Ууган Орхон ХХК шалгарч НАЗХГ-т гэрээ байгуулсан бөгөөд ажил хийгдэж байна. Хог тээврийн машин худалдан авах ажлын тендер сонгон шалгаруулалт зохион байгуулж "Хаштехник" ХХК шалгарч машиныг хүлээлгэн өгсөн. Хан-Уул дүүргийн 17, 18, 19, 20, 21 дүгээр хороодод шаардлагатай тавилга, эд хогшил худалдан авах ажлыг гүйцэтгүүлэхээр "Хашхан" ХХК-ийг шалгаруулж гэрээ байгуулж тавилга, эд хогшлыг нийлүүлээд байна. 15, 17, 19, 20, 21 дүгээр хороо, шинэ байранд орсон 3 дугаар хороог шилэн кабельд холбоход шаардлагатай кабель, тоног, төхөөрөмж нийлүүлэх ажлын тендерийг 2019 оны 11 сарын 14-нд дахин зарласан бөгөөд 11 сарын 21-нд нээлт хийсэн боловч нэг ч санал ирээгүй тул дахин тендер зарласан.

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/1002 дугаар захирамжаар нийслэлийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 8 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх дүүргийн Засаг даргад шилжин ирсэн. Үүнд:

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хороо	Батлагдсан төсөв	Ажлын явц
Тендер зарлагдсан				
1	Хорооны барилгыг төвлөрсөн цэвэр усны системд холбох ажил	13	50.0	10 сарын 23-нд тендер зарласан. 11 сарын 23-нд нээлт хийсэн. Үнэлгээ хийгдэж байна.
2	Явган хүний зам шинээр тавих, засварлах	15	30.0	2019.11.13-нд тендер зарласан. 12.13-д нээлт хийнэ.
3	Авто замын тэмдэг, тэмдэглэгээ, хурд сааруулагч хийх	15	20.0	2019.11.13-нд тендер зарласан. 12.13-д нээлт хийнэ.
4	120 мянгатын 19, 20 дугаар байрны дунд иж бүрэн тоглоомын талбайн тохижилт хийх	1	25.0	2019.11.15-нд тендер зарлагдсан. 12.16-нд нээлт хийнэ.

5	19 дүгээр хорооллын 32, 33 дугаар байрны дунд ахмадын иж бүрэн чийрэгжүүлэх тоног төхөөрөмж суурилуулах	1	25.0	10 сарын 29-нд тендер зарлагдсан. 11 сарын 03-нд нээлт хийсэн. "Вектор ус дриллинг" ХХК-тай гэрээ байгуулагдсан. Ажил он дамжин хэрэгжинэ.
6	19 дүгээр хорооллын 8, 9 дүгээр байрны дунд иж бүрэн тоглоомын талбайн тохижилт хийх	1	25.0	2019.11.13-нд тендер зарлагдсан. 12.13-нд нээлт хийнэ.
7	19 дүгээр хорооллын 31 дүгээр байрны дэргэд иж бүрэн тоглоомын талбайн тохижилт хийх	1	25.0	2019.11.15-нд тендер зарлагдсан. 12.16-нд нээлт хийнэ.
Тендер зарлагдах шатандаа				
8	Жаргалантын 1, 2, 3, 4 дүгээр гудамжны явган хүний замын ажил	7	100.0	Тус ажлыг Жаргалантын 1, 2 дугаар гудамжны тохижилтын ажил 50.0 сая, Жаргалантын 3, 4 дүгээр гудамжны тохижилтын ажил 50.0 сая төгрөг болгон хувааж нэршлийг өөрчлөн төсвийн задаргаа хийх саналыг Нийслэлийн Засаг даргад хүргүүлж өөрчлөлт оруулсан бөгөөд тендерийн баримт бичиг боловсруулж байна.
Нийт			300.0	

1.1.3 Нийслэлийн ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

Нийслэлийн Засаг даргын 2019 оны А/132, А/373 дугаар захирамжаар нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 800.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааны эрх дүүргийн Засаг даргад шилжин ирсэн.

№	Төсөл, арга хэмжээний нэр	Хороо	Батлагдсан төсөв	Ажлын явц
Гэрээ байгуулагдсан				
1	Гэрэлтүүлэг	13	60.0	Гүйцэтгэгчээр Лэдсити ХХК шалгарч ажил хэрэгжиж дууссан.
2	Камержуулалт	13	30.0	Гүйцэтгэгчээр Ооллинк ХХК шалгарч ажил хэрэгжиж дууссан.
3	Өрхийн эрүүл мэндийн төвийн автомашин	15	20.0	Гүйцэтгэгчээр Интел хайтек ХХК шалгарч ажил хэрэгжиж дууссан.

4	67 дугаар цэцэрлэг, 115 дугаар сургуулийн барилгын дээврийн засвар	1,15	79.0	Гүйцэтгэгчээр "Хүйс нутаг" ХХК шалгарч НХОГ-т гэрээ байгуулах зөвлөмж хүргүүлсэн.
5	Иргэдийн аюулгүй байдал, тохилог орчин, амьдрах нөхцөлийг сайжруулах	15	76.0	Гүйцэтгэгчээр "Хүйс нутаг" ХХК шалгарч ажил хэрэгжиж дууссан.
6	Иргэдийн аюулгүй байдал, тохилог орчин, амьдрах нөхцөлийг сайжруулах	1	75.0	Гүйцэтгэгчээр "Буян нэмэх интер" ХХК шалгарч ажил хэрэгжиж дууссан.
7	Оршуулгын газрын хашааг шинэчлэх	9	75.0	Гүйцэтгэгчээр "Вектор ус дриллин" ХХК шалгарч ажил хэрэгжиж дууссан.
8	Жишиг гудамж байгуулах	9	60.0	Гүйцэтгэгчээр "Өлкө констракшн" ХХК шалгарч гэрээ байгуулагдсан. Ажил хийгдэж байна.
9	Тохижилтын ажил	15	75.0	"Буян нэмэх интер" ХХК-тай гэрээ байгуулсан. Ажил хийгдэж эхэлсэн.
Гэрээ байгуулагдах шатанд				
10	Нийтийн эзэмшлийн талбайг хашаажуулах, ногоон байгууламж хийх	10	40.0	2 удаагийн тендер шалгаруулалт амжилтгүй болж шууд гэрээ байгуулах зөвлөмж ирсний дагуу гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж НХОГ-т зөвлөмж хүргүүлсэн.
11	Гудамжны тохижилт	9	25.0	2 удаагийн тендер шалгаруулалт амжилтгүй болж шууд гэрээ байгуулах зөвлөмж ирсний дагуу гэрээ байгуулахаар ажиллаж байна.
12	Орон сууцны байрнуудын гадна фасадын дулаалга /ХУД 13 дугаар хороо 3,4-р байр/	13	60.0	2 удаагийн тендер шалгаруулалт амжилтгүй болж шууд гэрээ байгуулах зөвлөмж ирсний дагуу гэрээ байгуулахаар ажиллаж байна.
13	Явган хүний зам барих, гүүрэн гарц барих	10	20.0	2 удаагийн тендер шалгаруулалт амжилтгүй болж шууд гэрээ байгуулах зөвлөмж ирсний дагуу гэрээ байгуулахаар ажиллаж байна.
Үнэлгээ хийгдэж буй				
14	Камержуулалт	10	40.0	11 сарын 19-нд тендер зарлагдсан, 2019 оны 27-нд нээлт хийсэн. Үнэлгээ хийгдэж байна.
Тендер зарлагдсан				

15	Орон сууцны хороолол хотхон дундах зам засвар, тохижилт	1,15	75.0	2019.11.13-нд тендер зарласан. 12.13-нд нээлт хийнэ.
	Нийт		810.0	

1.1.4 Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл

Дүүргийн ИТХ-ын 2018 оны 12 сарын 14-ны өдрийн 06 дугаар тогтоолоор орон нутгийн төсвийн хөрөнгөөр нийт шинээр 40 төсөл, арга хэмжээ хэрэгжихээр батлагдсан. /Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 30 төсөл, арга хэмжээ, орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 10 төсөл, арга хэмжээ/ Үүнд:

ХЭРЭГЖИЖ ДУУССАН-17

- Төлөөлөгчдийн үйл ажиллагаанд шаардлагатай Агаарзүлгийн тонки төмөрлөм хурдлан авах
- Засаг даргын Тамгын газарт автомашин худалдан авах
- Чанд ажил ЭЗМТ-ийн засвар
- Төрийн албан хаагчдын албан хэрэгсэлд компьютер, тонки төмөрлөм худалдан авах
- Зуул мундгийн тавийн Яармаг салбарын бөөлөгчн засвар
- Өргөдөл, голдод хүлээн авах мобайл аппликейцн хийх
- 60-р сургуулийн гадна авто зогсоол
- Усан сан /төмөрлөгч, гүний худал засварлах
- 32-р сургуулийн хөл бөмбөг, сэгсэн бөмбөгийн талбай байгуулах
- 63-р сургуулийн автобусны гараж
- Грейдер худалдан авах
- 11, 12-р хороодод цэцэглэвч хүчлэл сайжруулах
- Ковш худалдан авах
- Спорт хорооны тохижилт
- 5,9,10,16-р хороодод кишиг гудамж байгуулах
- 15-ийн үйлчилгээний төв орчимд тохижилт
- 16-р хорооны гудамжны тохижилт

ГЭРЭЭ БАЙГУУЛАХ ШАТАНД-3

- 4,5,6,7,8-р хороодын нэг цэг, гадна фасадны засварын ажил
- Хороодын нэг цэг, гадна фасадны засварын ажил 11,2,15-р хороод
- 6, 7-р хорооны ус зайлуулах шугам татах

ХЭРЭГЖИЖ БҮЙ-7


- Зурга төсөл
- Засаг дунд зог, авто замын байр зүйн тэмдэглэгээ хийх – ахлын явц – 96%
- Татварын хэлтсийн байрны засвар – ахлын явц – 80%
- ОН ДАМЖИН ХЭРЭГЛИХ
- Соёлын Оданы засварын ажил – ахлын явц – 70% /ОН дамжин хэрэгжүүлэх/
- Түүл голын эрэг дагуу энэ зурвас байгуулах – ахлын явц – 85% /ОН дамжин хэрэгжүүлэх/
- Ахмадын сүүлчийн баригта барих – ахлын явц – 10% /ОН дамжин хэрэгжүүлэх/
- 10, 13, 14, 15-р хороодын нэг цэг, гадна фасадны засварын ажил – ахлын явц – 50% /ОН дамжин хэрэгжүүлэх/

ТЕНДЕР ЗАРЛАГДСАН-2

- 15-р хорооны зам талбайн тохижилт /11 сарын 22-нд нээлт хийсэн. Үнэмлэг хийгдэх байна/
- 11-р хороонд нийтийн бие засах газар байгуулах /тендер зарлагдсан 12 дугаар сарын 13-нд нээлт хийнэ. Материал хүлээн авч байна/

БУСАД-1

- 67-р /үндэслэлийн бөмбөг, тамирын зарлагы өргөтгөл-1-ОХЭГ-ийн /мэргэжлийн зөвлөлийн хурлаар дэмжигдээгүй/ Наршилд өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа



1.1.5 Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл

Улс, нийслэлийн төсөв, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжих худалдан авах ажиллагааны эрх шилжин ирсэн 16 төсөл, арга хэмжээ, дүүргийн төсвийн хөрөнгөөр санхүүжин шинээр хэрэгжүүлж буй 40 төсөл, арга хэмжээний явцын мэдээллийг ДИТХ-ын Ажлын албанд 2019 оны 05-р сарын 06-ны өдрийн 06/867 тоот албан бичгээр хүргүүлсэн.

2019 оны 04 сарын 08-наас 05 сарын 08-ны хооронд зохион байгуулагдсан дүүргийн ОНХС-ийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх арга хэмжээний цахим санал асуулгад нийт 4 хорооны 18-аас дээш насны 33648 иргэн санал өгөхөөс 6298 иргэн санал өгсөн байна. Оролцооны дундаж 18.72 хувь байна. Дүнг хороодоор харуулвал:

№	Төсөл, арга хэмжээний нэршил	Хороо	Төсөвт өртөг	Ажлын явц
1	Камержуулалт	1,2,3,5,6,7,8,9,13,14,15	377.7	2019 оны 05 сарын 15-ны өдөр тендер зарлагдсан. 06 сарын 17-ны өдөр нээлт хийсэн. Гүйцэтгэгчээр Ай Ти Зон ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажил хүлээлцэх шатандаа үргэлжилж байна.
2	Гэрэлтүүлэг	3,4,10,11,12,16	252.1	2019 оны 05 сарын 07-ны өдөр тендер зарлагдсан. 06 сарын 07-нд нээлт хийсэн. Гүйцэтгэгчээр Хануй Энержи ХХК шалгарч гэрээ байгуулсан. Ажил хийгдэж дууссан.



Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2020 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний цахим санал асуулга авах ажлыг 2019 оны 1-р ээлжийн цэрэг татлагад хамрагдаж буй залуучуудаас 4 хорооны зохион байгуулагч нартай хамтран зохион байгуулсан.



Нийслэл дэх төрийн аудитын газраас хийсэн гүйцэтгэлийн аудитад 2018 оны дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний хэрэгжилт, үр дүнг байршил бүрээр шалгуулсан.



Дүүрэгт 2020-2024 онуудад барих шаардлагатай сургууль, цэцэрлэгийн судалгаа нэгтгэн гаргаж НЗДТГ-т 05 сарын 24-ны өдрийн 06/1019 тоот албан бичгээр хүргүүлсэн.

ХАН-УУЛ ДҮҮРЭГТ 2020-2024 ОНД ШААРДЛАГАТАЙ ЦЭЦЭРЛЭГИЙН СУДАЛГАА

№	Хороо	№	Ашиглалт ад орсон он	Хүчин чадал	Хамрагдаж буй хүүдийн тоо	Хамрагдах ёстой хүүдийн тоо	Өргөтгөх болон шинээр барих шаардлагатай цэцэрлэгийн хүчин чадал				
							2020	2021	2022	2023	2024
1	1	53	1965	140	315	1089				280	
2		67	1973	280	605			280			
3		Шинэ					280				
4	2	12	1966	115	247	1722	280				
5		27	2015	200	697						280
6		72	1976	140	504				280		

7		65	1973	280	682		120	280			
8		Шинэ						280			
9	3	4	1957	-	57	2450					
10		28	1959	-	53						
11		41	1986	280	690				280		
12		46	2017	240	523				280		
13		Шинэ					280				
14	4	145	2008	75	135	1480	100				
15		Шинэ					280				
16	5	29	1978	140	219	553		150			
17		71	1979	180	303			150			
18	6	189	2012	100	251	668		240			
19		Шинэ					280				
20	7	73	1964	150	377	483					
21		Шинэ					280				
22	8	209	2014	240	491	1122		150			
23		Шинэ					280				
24	9	134	1985 2014	275	607	1044					
25		Шинэ					280				
26	10	49	1960	100	360	1679		240			
27		219	2015	120	205					150	
28		230	2014	150	405						
29		250	2017	240	527						
30	11	35	1959 2016	240	625	2188				280	
31		Шинэ					280				
32	12	121	1976	140	90	585					
33		190	2013	100	187						150
34	13	144	1964, 2018	225	308	375				150	
35	14	165	2008	75	328	519					
36	15	218	2015	120	458	3232	150		280		
37		Шинэ 1					280				
38		Шинэ 2						280			
39	16	223	2015	150	280	1612	150				
40		243	2016	240	494				150		
41		Шинэ						280			
ДҮН				4735	11023		332 0	2050	127 0	860	430

ХАН-УУЛ ДҮҮРЭГТ 2020-2024 ОНД ШААРДЛАГАТАЙ СУРГУУЛИЙН СУДАЛГАА

№	Хороо	Сургууль	Ашигла лтад орсон он	Хүчин чадал	Хамраг даж буй хүүдийн тоо	Эзлэгийн коэффициент	Өргөтгөх болон шинээр барих шаардлагатай сургуулийн хүчин чадал				
							2020	2021	2022	2023	2024
1	1	52	1957	1240	3574	2.8		960			
2		Шинэ 1					960				
3	2	75	1980	920	1043	1.1	960				
4		15	1974	920	1704	1.8		960			
5	3	18	1978	920	2414	2.6	640				
6		Шинэ 1								960	
7	4	34	1976	920	1090	1.1	640				
		Шинэ 1							960		
8		63	1992	360	251	0.6				180	
9	5	41	1969	920	1278	1.3			660		
10	7	60	1974	1400	1270	0.9		960			
11	8	118	2011	640	1488	2.3	320				
12		Шинэ 1								960	
13	9	114	2007	640	1421	2.2	320				
14	10	135	2015	180	191	1			320		
15	11	32	2007 2017	1240	1307	1					640
16	12	10	1963	880	806	0.9	960				
17	13	26	1964	320	610	1.9			640		
18	14	59	1994	360	759	2.1	640				
19	15	115	2009	640	1843	2.8	960				
20		130	2015	180	533	2.9					
21		Шинэ 1						960			
22		Шинэ 2							960		
23	16	7	1939	864	2747	3.1					
ДҮН				1354 4	24329	1.8	640 0	3840	354 0	210 0	640

1.2 Дэд бүтэц, дахин төлөвлөлтийн ажлын хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

Дүүргийн 5 дугаар хорооны оршин суугч иргэдэд гэр хорооллын дахин төлөвлөлтийн үйл ажиллагааны танилцуулга, мэдээлэл хийж, иргэдийн санал хүсэлтийг Нийслэлийн гэр хороолол дэд бүтцийн газар уламжилсан



Дүүргийн 3 дугаар хороо Арьс ширний 19 байр, 4 дүгээр хороо 5, 6-р байр, 6 дугаар хороо 20-1, 20-2 дугаар байр, 13 дугаар хороо 2-р байрнуудын оршин суугч иргэдээс "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагаа"-ны санал асуулга авч, саналыг нэгтгэн боловсруулж, Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газарт, 11, 13 дугаар хороодын ашиглалтын шаардлага хангахгүй, газар хөдлөлтөд тэсвэргүй болохыг мэргэжлийн байгууллагаас тогтоосон барилга байгууламжийн судалгаа гарган Монгол Улсын Их хурлын гишүүн, Хууль зүй дотоод хэргийн сайдад, дүүргийн нутаг дэвсгэрт ашиглагдаж байгаа болон улс, нийслэл, бусад хөрөнгийн эх үүсвэрээр шинээр баригдах сургууль, цэцэрлэг, эмнэлэг мөн ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууц болон барилга байгууламжийн жагсаалт гаргаж Монгол Улсын Шадар сайд Ө.Энхтүвшин, Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газарт тус тус уламжилсан.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй 28 дугаар цэцэрлэгийн барилгын батлагдсан зураг, ерөнхий төлөвлөгөөнд туссан орц гарцны асуудлыг шийдвэрлүүлэхээр Тамгын газрын даргын 2019 оны 05 сарын 22-ны өдрийн 06/9998 тоот албан бичгээр Хот байгуулалт, хөгжлийн газарт уламжилсан бөгөөд шийдвэрлэлтийн хариу ирүүлээгүй байна.

Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны оршин суугч иргэдэд орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагааны танилцуулга, газар хөдлөлтийн гамшгийн эрсдлээс урьдчилан сэргийлэх эсдэвт сургалтыг 3, 4, 6, 10, 11, 12, 13 дугаар хороодын 200 гаруй иргэдэд зохион байгуулсан.

Д/д	Хороо	Барилгын дугаар	Өрхийн тоо	Зохион байгуулах хугацаа	Зохион байгуулагдах байршил
1.	3 дугаар хороо	Талхны 20 байр	96	III/02-ны 10:00 цагт	

2.	11 дүгээр хороо	Сүрьеэгийн 20 байр			18 дугаар сургуулийн урлаг зааланд
3.	4 дүгээр хороо	5,6 дугаар байрууд	80	III/02-ны 14:00 цагт	41 дүгээр сургуулийн урлаг зааланд
4.	6 дугаар хороо	20-1, 20-2 байрууд			
5.	10 дугаар хороо	34,35 дугаар байрууд	96	III/09-ний 10:00 цагт	МИАТ ХК-ны спорт зааланд
6.	12 дугаар хороо	39 дүгээр байр			
7.	13 дугаар хороо	1,2,3,4,5 дугаар байрууд, 2А-10 байр	110	III/09-ний 14:00 цагт	13 дугаар хорооны иргэний танхимд



Дээрх сургалтын үр дүнд Монгол Улсын Мэргэжлийн хяналтын Улсын ахлах байцаагчийн 2014.07.10-ны өдрийн 01-01/05 шийдвэрт туссан дүүргийн 3 дугаар хорооны Талхны 20 дугаар байр, Арьс ширний 19 байр, 4 дүгээр хороо 5, 6-р байр, 6 дугаар хороо 20-1, 20-2 дугаар байр, 13, дугаар хороо 2-р байрнуудын оршин суугч иргэдээс "Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барих үйл ажиллагаа"-ны санал асуулга авч, саналыг нэгтгэн боловсруулж, Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны 04 сарын 12-ны 06/703 тоот албан бичгээр Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газарт уламжилсан.

Дүүргийн 5 дугаар хороонд хорооны Яармагийн 1, 2, 3 дугаар гудамж, Цогийн 1 дүгээр гудамжны 227 нэгж талбарын гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгч Ама констракшн ХХК нь төсөл хэрэгжүүлэх байршлын газар болон үл хөдлөх хөрөнгийн эзэмшигч, өмчлөгч иргэдтэй гурван талт гэрээ байгуулан ажиллаж байна.

Дүүргийн 8 дугаар хорооны "А" хэсэгчилсэн талбайд гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгч Ажнай цэгц ХХК болон "Б" хэсэгчилсэн талбайд гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төсөл хэрэгжүүлэгч Баярс констракшн ХХК-уудын барилгажилтын ажил удаашралтай, төслийн талбайн иргэдээс удаа дараа гомдол ирсний улмаас нийслэлийн Засаг даргын 2019 оны А/461 дүгээр захирамжаар байгуулагдсан хяналтын хорооны хурлаар төсөл хэрэгжүүлэх эрхийг нь цуцлах тухай санал гарсан.

Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж буй Зайсан орчмын орон сууцны хотхонуудын дулаан хангамж болон усан хангамжийн зургийн дагуу Хот байгуулалт хөгжлийн газар, нийслэлийн Автозам хөгжлийн газар, Хөрөнгө оруулалтын газар, Улаанбаатаар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК, Богдхан уулын дархан цаазат газрын захиргааны холбогдох мэргэжилтнүүдтэй трассыг газар дээр нь судалж, зөвшилцөн ажилласан.



Зайсан орчмын орон сууцны хотхонуудын дулаан хангамжийн ажлын цахилгааны техникийн нөхцөлийн хүсэлтийг Улаанбаатаар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК- гаргасан.Тус төсөл арга хэмжээг гүйцэтгэгчээр Бумба Од ХХК шалгарсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн "Морингийн давааны хатуу хучилттай 1.2 км авто зам"-ын барилгын ажлыг байнгын ашиглалтад авах улсын комисс 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр ажилсан.



Дүүргийн нутаг дэвсгэрт орших ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 34 орон сууцны байрыг дахин барилгажуулахаар 15 багцад хувааж, төлөвлөлт хийснээс, 8 багцын 24 байранд төсөл гүйцэтгэгч шалгарч дахин төлөвлөлтийн ажил явагдаж байна. Үүнд баригдаж дууссан 4, барилгыг бууж барилгын ажил эхэлсэн 12, ажил эхлээгүй 8 дахин төлөвлөлтийн барилга байна. Үлдсэн 7 багцын багц-6 /10 дугаар хороо Нисэхийн 34, 35/, багц-8 /12 дугаар хороо Биокомбинатын 39/, багц-9 /3 дугаар хороо Арьс ширний 31/, багц- 11 /Сүрьеэгийн эмнэлгийн ажилчдын 20 дугаар байр/, багц- 13 /3-р хороо Талхны 20-р байр/, багц- 14 /4-р хороо 5, 6-р байр/, багц- 15 /6-р хороо 20-1, 20-2-р байр/ зэрэг нийт 10 барилгыг буулган шинээр барих төсөл хэрэгжүүлэгчийг сонгон шалгаруулах урилгыг өдөр тутмын хэвлэлд 10 гаруй удаа нийтэлсэн боловч санал ирээгүй улмаас гүйцэтгэгч шалгараагүй тул сонгон шалгаруулалтын урилгыг 2019 оны 11 дүгээр сарын 21-ны өдөр дахин зарлаад байна.



Нийслэлийн Засаг даргаас эрх шилжиж эрсэн 13 дугаар хорооны гэрэлтүүлгийн ажлын техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг боловсруулж, зураг төсвийн хамт дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд хүлээлгэн өгсөн. Тус төсөл арга хэмжээг Лед Сити ХХК хийж гүйцэтгэсэн.

Нийслэлийн Засаг даргаас эрх шилжиж эрсэн 13 дугаар хорооны камержуулалтын ажлын техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг боловсруулж, дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд 4 дүгээр сарын 22-ны өдөр хүлээлгэн өгсөн. Тус төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр Олл Линк ХХК шалгаран ажлыг гүйцэтгэсэн.

Нийслэлийн Засаг даргаас эрх шилжиж эрсэн 13 дугаар хорооны гэрэлтүүлгийн ажлын техникийн тодорхойлолт, ажлын даалгавар боловсруулж, зураг төсвийн хамт дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд хүлээлгэн өгсөн. Төсөл арга хэмжээний тендер баримт бичигт үнэлгээ хийгдэж байна. Мөн нийслэлийн төсвийн 95 сая төгрөгийн хөрөнгөөр дүүргийн 13-р хорооны 26, 6-р хэсэгт хэрэгжих гэрэлтүүлгийн ажлын байршил, трассыг судалж, Улаанбаатар хотын Захирагчийн албанд хүргүүлсэн.

Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 1, 2, 3, 5, 6, 7, 8, 9, 13, 14, 15 дугаар хороонд хэрэгжүүлэх нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн камержуулалтын ажлын техникийн тодорхойлолтыг боловсруулж дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд хүлээлгэн өгсөн. Тус төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр Ай Ти Зон ХХК шалгарсан. Ажлын явц 95 хувьтай 2019 оны 12 дугаар сарын 05-нд 180 ширхэг камерийг ашиглалтад хүлээлгэн өгнө.

Дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 3, 4, 10, 12, 16 дугаар хороонд хэрэгжүүлэх нийтийн эзэмшлийн гудамж зам талбайн гэрэлтүүлгийн зураг төсвийг "Оргилт-Од" ХХК-р гүйцэтгүүлж, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврыг боловсруулж дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд хүлээлгэн өгсөн. Тус төсөл арга хэмжээний гүйцэтгэгчээр Хануй Энержи ХХК шалгарч 2019 оны 10 дугаар сарын 01-нд 136 ширхэг гэрэлтүүлгийг ашиглалтад оруулсан.

Дүүргийн төсвийн хөрөнгөөр 11-р хороонд хэрэгжих "Нийтийн бие засах газрын ажил"-ын кадастрын зураг хийлгүүлж, газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа хийлгэж, газрын гэрчилгээг 08 сарын 23-ний өдөр Монгол улсын Байгаль орчин аялал жуулчлалын яамнаас авсан. Тус төсөл арга хэмжээний тендерийн баримт бичигт үнэлгээ хийгдэж байна.



Дүүргийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 10, 13, 14, 16-р хорооны "Хороодын нэг цэгийн үйлчилгээний тохижилт, хаягжуулалт, гадна фасадны дизайныг нэгдсэн нэг стандарттай болгох" ажлын зураг төсөв, магадлалын ерөнхий дүгнэлтийг 2019 оны 05 сарын 22-ны өдөр дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд хүлээлгэн өгсөн.

1.3 Барилга, зураг төслийн ажил, үр дүнтэй холбоотой мэдээлэл

Дүүргийн Худалдан авах ажиллагааны албанд тендер зарлах шаардлагатай ажлын зураг төсөв, холбогдох баримт бичгийг бүрдүүлэн боловсруулж хүлээлгэн ажиллав. Үүнд:

- Зураг төсөвт магадлал хийгдсэн ажил **16**
- Техникийн тодорхойлолт **5**
- Зургийн даалгавар **18-г** боловсруулж, батлуулан холбогдох газарт хүргүүлж ажилласан.

Төрийн болон орон нутгийн өмчийн үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, дахин үнэлэх ажлын хүрээнд Барилга, авто зам, гүүр, явган зам, автобусны буудлуудын тоо хэмжээ, байршлыг нэгтгэсэн үнэлгээ хийж буй байгууллагад баталгаажуулан хүргүүлсэн.

Нэг хот, нэг стандарт аяны хүрээнд Нийслэлийн захирагчийн ажлын алба, Нийслэлийн хот төлөвлөлт, ерөнхий төлөвлөгөөний газрын ажлын хэсэгтэй хамтран дүүргийн явган зам хийх нэн шаардлагатай газруудаар хамт явж ажлын зураг авалт хийв.



Техник хяналтаар давхардсан тоогоор нийт 67-н удаа явж ажлын явцад хяналт тавиж ажиллав.

10 дугаар хороо. 4 улиралын цэцэрлэгт хүрээлэн байгуулах ажил /Ажлын гүйцэтгэл 90%/



10, 12, 13, 14 дүгээр хороодод автобусны буудал барих ажил /Ажлын гүйцэтгэл 100%. он дамжин хэрэгжсэн/



Соёлын ордоны гадна цасад засварын ажил /Ажлын гүйцэтгэл 90%/.




Хороодын байрны гадна фасад, нэг цэгийн байрны засварын ажил /Ажлын гүйцэтгэл 80%/.



Ахмадын сувилалын барилгын ажлын эскиз зургийг баталгаажуулан гүйцэтгэгчээр "Наран босголт" ХХК шалгаран ажлыг гүйцэтгэж байна. Ажлын гүйцэтгэл 20%.



1.3.1 Хот төлөвлөлт, судалгааны ажил, түүний үр дүнтэй холбоотой мэдээлэл



Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн зорилтыг хангуулах хүрээнд хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын мэдээллийн нэгдсэн санг үүсгэх зорилгоор хот төлөвлөлт, дэд бүтэц, тохижилтын чиглэлээр бүрэн хэмжээний суурь судалгааны ажлыг эхлүүлсэн.

Үүнд:

1. Хан-уул дүүргийн нийт ногоон байгууламжийн судалгаа.
2. Хан-уул дүүргийн ногоон байгууламж шинээр хийх шаардлагатай байршлын судалгаа.
3. Хан-уул дүүргийн авто зам, явган зам, авто зогсоолын судалгаа.
 - Төв замын судалгаа
 - Туслах замын судалгаа
 - Хороолол дундах автозамын судалгаа
 - Явган замын судалгаа
 - Авто зогсоолын судалгаа
4. Хан-уул дүүрэгт шинээр авто зогсоол хийх байршлын судалгаа.
5. Хан-уул дүүргийн шороон хөрс бүхий талбайн судалгаа.
6. Хан-уул дүүргийн гадна тохижилт, тоглоомын талбайн судалгаа.
7. Хан-уул дүүрэгт шинээр хийх шаардлагатай гадна тохижилт, тоглоомын талбайн судалгаа.
8. Хан-уул дүүргийн үерийн далан сувгийн судалгаа.
9. Хан-уул дүүрэгт ус ихээр тогтдог газрын судалгаа.
10. Хан-уул дүүргийн гэрэлтүүлгийн судалгаа.
11. Хан-уул дүүрэгт шинээр хийх шаардлагатай гэрэлтүүлгийн судалгаа.
12. Хан-уул дүүргийн камержуулалтын судалгаа.
13. Хан-уул дүүрэгт шинээр хийх камержуулалтын судалгаа.

14. Нийтийн зориулалттай орон сууцны судалгаа, нийт 14 төрлийн нарийвчилсан судалгааны ажлыг хороодоос хүлээн авч нэгтгэж дууссан.

Дүүргийн иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, түргэн шуурхай үйлчлэх зорилгоор “Явуулын оффис” үйлчилгээг санаачлан төслийн хэрэгжүүлхээр бэлдэж байгаа бөгөөд “Хорооны хөгжил, төрийн үйлчилгээ” дэд хөтөлбөрийн ажлын хэсэгт танилцуулсан.



1.4 Үндэсний хөтөлбөрт заасан хэрэгжих зорилтын хүрээнд гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

НЗД-ын 2017 оны 335 дугаар захирамжийн дагуу үндэсний хөтөлбөрүүдийн 2018 оны хэрэгжилтийн тайланд дүн шинжилгээ хийж, хугацаанд нь буюу 2019 оны 1-р сарын 20-ны дотор НЗДТГ-ын ХШҮХ-т хүргүүлсэн.

УИХ болон Засгийн Газрын тогтоолоор батлагдсан нийт 43 үндэсний хөтөлбөрөөс дүүргийн хэмжээнд 39 үндэсний хөтөлбөрийн 160 зорилтыг хэрэгжүүлж байна. 2019 оны эхний хагас жилийн байдлаар **70.5** хувьтай, жилийн эцсийн байдлаар **95** хувьтай хэрэгжсэн байна.

хөтөлбөрүүдийн хүрээнд хийгдсэн ажлуудаас:

1. “Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах” үндэсний хөтөлбөр

Монгол Улсын засгийн газрын 2016 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах” үндэсний хөтөлбөрийг 2019 онд Хан-Уул дүүрэгт хэрэгжүүлэх ажлын нэгдсэн төлөвлөгөө болон хөтөлбөрт хамрагдсан 987 өрхийг Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад, хороод хариуцан ажиллах хуваарийг баталсан. Батлагдсан хуваарийн дагуу дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад зорилтот өрх бүрээр очиж нөхцөл байдлыг үнэлэн өрхүүдийн тулгамдсан асуудлуудыг тодорхойлсон.

Хороодын Засаг дарга нар, дэргэдэх хэлтэс албадын дарга нарын өргөтгөсөн 3 удаа хурлыг зохион байгуулж зорилтот өрхүүдэд хийгдсэн үнэлгээ, нөхцөл байдал, авах арга хэмжээг хэлэлцэн олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд хамруулах, Хөдөлмөрт бэлтгэх, хөдөлмөр эрхлэлтийн үр чадвар олгох, Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих, Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээг хөгжүүлэх хөтөлбөрүүдэд хамруулах талаар мэдээлэл солилцсон.



Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад болон хороод хамтран зорилтот өрхүүдтэй ажиллах төлөвлөгөөний дагуу ажилласаны үр дүнд;

- ✓ Бичиг баримтжуулсан-31,
- ✓ Эрүүл мэндийн үзлэгт хамруулсан-100,
- ✓ Цэцэрлэгт хамруулсан-35,
- ✓ Ажилд зуучилсан-32,
- ✓ Сургалтад хамруулсан-87,
- ✓ Гэр олгосон-11,
- ✓ Аян өрнүүлсэн- 5,
- ✓ Тусламж, дэмжлэг үзүүлсэн-774 хүүхдэд баярын бэлэг, 76 хүүхдэд хичээлийн хэрэглэл, 139 иргэнд дулаан хувцас хандивласан, 15 өрхөд хүнсний тусламж, 34 сайжруулсан шахмал түлш хандивласан.



Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 16 дугаар тогтоолоор батлагдсан “Зорилтот өрхийн хөгжил, хамгааллыг сайжруулах” үндэсний хөтөлбөрт хамрагдсан өрхийн 250 хүүхдүүдийг халамжийн 28 дугаар цэцэрлэг, клиник 4 дүгээр сувилалд хамруулсан бөгөөд өрхийн амьжиргааг дээшлүүлж заавал хөгжих 418, хөгжлийн төлөөх өрх 366, хөгжлийг дэмжигч өрх 158, хөгжлийн бүтээгч өрх 38 болж хөтөлбөрт хамрагдсан өрхүүдийн амьжиргааны түвшин суурь үеийн түвшингээс 40,7% болж хөгжлийн түвшин ахисан.

2. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих хөтөлбөр

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг Хан-Уул дүүрэгт хэрэгжүүлэх үүрэг бүхий дүүргийн "Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн салбар зөвлөл"-ийг дүүргийн Засаг даргын 2019 оны А/45 дугаар захирамжаар шинэчлэн 15 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан бөгөөд салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. Салбар зөвлөлөөс 2019 онд төлөвлөгөөнд тусгагдсан 55 ажлыг 76,2 хувьтай хэрэгжүүлсэн.



Төв цэнгэлдэх хүрээлэнгийн гадна талбайд "Эрүүл аз жаргалтай ирээдүй" өдөрлөгийг 05 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулсан бөгөөд өдөрлөгт дүүргийн хөгжлийн бэрхшээлтэй 512 хүүхэд, тэдний эцэг эх оролцож, Хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамж үйлчилгээний мэдээлэл болон Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, нийгмийн хамгааллын талаарх танилцуулга мэдээлэл, эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээ, эрүүл мэнд, нийгмийн даатгалын үйлчилгээг нэг дороос хүргэсэн.



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн "Алтан намар" урлагийн наадмын 1 дүгээр шатны шалгаруулалтыг зохион байгуулах удирдамжийн дагуу тус урлагийн наадмыг 09 дүгээр сарын 10-ны өдөр дүүргийн Соёлын ордонд зохион байгуулсан. Шалгаруулалтад гоцлол дуу, хамтлаг дуу, гоцлол хөгжим, хамтлаг хөгжим гэсэн 4 төрөлд өрсөлдөж эхний 3 байрт шалгарсан 7 иргэн "Алтан намар" урлагийн наадмын II шатны шалгаруулалтад Нийслэлд өрсөлдөхөөр эрхээ авсан.



3. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн үндэсний хөтөлбөр

Олон Улсын хөдөлмөрийн байгууллагаас 2019 оныг "Эрүүл, аюулгүй ирээдүйн хөдөлмөрийн төлөө" уриатайгаар зарласан бөгөөд Монгол Улсын Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яам, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн сарын аян-2019" аяныг зарласан. Тус аяны хүрээнд Хан-Уул дүүрэгт 6, салбар зөвлөлийн 2019 оны үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөнд 5 ажлыг төлөвлөн нийт 11 үйл ажиллагааг 76 хувьтай хэрэгжүүлэн ажилласан.

Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд зориулан "Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэхэд хөдөлмөрийн аюулгүй байдал яагаад чухал вэ?", "Аюулгүй ажиллагааг хангахад анхаарах зүйл", "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчинд нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль" сэдэвт сургалтыг "OSHMI" сургалтын төв, Нийгмийн даатгалын хэлтэстэй хамтран зохион байгууллаа. Сургалтад жижиг дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгжийн 35 удирдах ажилтан хамрагдсан.



Дүүргийн төрийн өмчит ерөнхий боловсролын сургуулийн захирал, цэцэрлэгийн эрхлэгчдэд "Хүүхдийн аюулгүй байдлыг хангахад сургууль, цэцэрлэг дээрх хийгдэх ажлууд,

тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам" сэдэвт сургалт зохион байгуулж сургууль, цэцэрлэгийн 42 удирдах ажилтныг хамруулсан.



Дүүргийн "Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зөвлөл"-ийн дарга, Засаг даргын нэгдүгээр орлогч Г.Батсайханы санаачлагаар жижиг дунд үйлдвэр эрхлэгч аж ахуйн нэгж болон сургууль, цэцэрлэгүүдээр хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн ханган ажиллаж байгаа байгууллага шалгаруулах, туршлагыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Дарцаг" аялуулсан.



4. Дархлаажуулалтын үндэсний хөтөлбөр

Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/207 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2019 оны А/186 дугаар Захирамжын хүрээнд ерөнхий боловсролын сургуулийн 10-18 насны хүүхдүүдийг "Улаан бурхан, улаанууд" өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын 10 хоногийн аяныг зохион байгуулсан. Дархлаажуулалтад хамрагдвал зохих 20349 хүүхдийн 97,3 хувь буюу 19663 хүүхдийг хамруулсан. Дархлаажуулалтыг ерөнхий боловсролын сургууль болон их дээд сургууль, коллеж, Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвүүд дээр 33 түр цэг, явуулын 13 баг 39 хүний бүрэлдэхүүнтэйгээр хийж гүйцэтгэсэн.




"Дархлаажуулалтын 10 хоног"-ийн хүрээнд 7,15 настай хүүхдүүдийг сахуу татранги өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинд хамруулах тухай 07/1868, 07/1869, 07/1870, 07/1871, 07/1872 дугаар тоот албан бичгийг дүүргийн 18 сургууль, 5 мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төв болон коллежуудад тус тус хүргүүлж нийт 5670 хүүхдийг вакцинд хамруулсан.

5. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор батлагдсан "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн 5 зорилтын хүрээнд Жендэрийн салбар хорооноос 19 ажил үйлчилгээг төлөвлөн 96 хувийн гүйцэтгэлийн биелэлттэй ажиллаа.

Жендэрийн талаарх статистикийн нэгдсэн мэдээллийн санг бүрдүүлэхэд шаардагдах статистик тоо мэдээллийг бүрдүүлж, дүүргийн бодлого боловсруулах түвшний ажилтнуудад хүргэж ажилласан. Дүүргийн хүн ам 2018 оны статистик мэдээгээр 178919 байгаагаас 85457 буюу 47,8 хувь нь эрэгтэй, 93462 буюу 52,2 хувь нь эмэгтэй байна.



Жендэрийн мэдрэмжтэй бодлого, төлөвлөлт, төсөв хийх хүрээнд.

Дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга, албан хаагчид, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын дарга, 16 хороодын Засаг дарга болон хөгжлийн нийгмийн ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах заалтыг тусгуулж, үр дүнг тооцон ажилласан.

Засаг даргын Тамгын газар болон Засаг даргын дэргэдэх хэлтэс албадын дарга нар нийт 32 удирдах ажилтан Жендэрийн Үндэсний хорооноос зохион байгуулсан удирдах

ажилтны цахим сургалт, 2019 оны 06 дугаар сарын 20-ны өдөр Жендэрийн Үндэсний хорооны байранд танхимын сургалтад хамрагдаж Ж-1 сертификат гардан авсан.

Эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн гэр бүл, нийгэмд гүйцэтгэх үүрэг оролцооны талаарх хэвшмэл ойлголтыг өөрчлөхөд чиглэсэн жендэрийн боловсрол олгох сургалт, сурталчилгааны ажлын хүрээнд:

Хороодын хамтарсан багийг чадваржуулах, иргэдэд жендэрийн тухай хэвшмэл ойлголт, жендэрт суурилсан хүчирхийлэл, хүүхэд хамгаалал болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар сургалт, мэдээлэл өгөх нэгдсэн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлсэн. Хороодын хамтарсан багийг чадваржуулах, иргэдэд жендэрийн тухай хэвшмэл ойлголт, жендэрт суурилсан хүчирхийлэл, хүүхэд хамгаалал болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх талаар сургалт, мэдээлэл өгөх нэгдсэн төлөвлөгөөг батлуулан хэрэгжүүлсэн. Хэрэгжилтийг хангах хүрээнд хамтарсан багийн гишүүдийг чадваржуулах сургалт 4 удаа, кейс хэлэлцүүлэг 4 удаа, иргэдэд жендэрийн тухай хэвшмэл ойлголт, жендэрт суурилсан хүчирхийлэл, хүүхэд хамгаалал болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх зорилгоор "Жендэрийн хандлагаа эерэг болгоё" аяныг 2019 оны 08 дугаар сарын 20-ны өдрөөс 3 сарын хугацаанд зохион байгуулж ерөнхий боловсролын 10 сургууль, их дээд сургууль, коллеж, МСҮТ-ийн 6 сургууль, 8 төрийн байгууллага, 21 хорооны иргэнд 23 удаагийн сургалт, 2 тэмцээн уралдаан, 1 уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж аяны хүрээнд 4288 иргэнийг хамруулсан.

Хамтарсан багийг чадваржуулах, иргэдэд жендэрийн талаарх мэдлэг мэдээлэл өгөх нийт 64 удаагийн сургалт, арга хэмжээнд нийт 5450 иргэнийг хамруулсан.

Дүүргийн жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг боловсруулах Ажлын хэсэг 4 удаагийн хуралдаан, хэлэлцүүлгийг зохион байгуулж, төсөлд санал авах ажил үргэлжилж байна.



6. Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 270 дугаар тогтоолоор батлагдсан "Хүүхдийн хөгжил, хамгааллын үндэсний хөтөлбөр"-ийн хүрээнд 2019.05.23-ны өдөр "Хүүхдээ сонсох өдөр"-ийг дүүргийн Соёлын ордонд зохион байгууллаа. Тус үйл ажиллагаанд Ерөнхий боловсролын 16 сургуулийн 130 төлөөлөгч хүүхдүүд оролцон "Сургуулийн орчин", "Гэр бүлийн орчин", "Нийгмийн орчин", "Цахим орчин" 4 сэдвийн хүрээнд тулгамдаж буй асуудлаа ярилцан, өөрсдийн санал хүсэлтийг илэрхийллээ. Үйл ажиллагаанд дүүргийн Засаг дарга болон холбогдох хэлтэс албадын дарга нар оролцож сурагчдын асуултад хариулж өмнөх үйл ажиллагааны явцад гарсан саналыг хэрхэн хэрэгжүүлсэн талаар мэдээлэл өгсөн.



Хүүхэд хамгааллын үйлчилгээний мэдээлэл хяналтын тогтолцоог бэхжүүлж, Хүүхдийн асрамж, халамжийн төвүүдэд гэр бүлийн хувилбарт үйлчилгээг нэвтрүүлэх замаар хараа хяналтгүй, хөдөлмөр эрхэлдэг, хүчирхийлэлд өртсөн, эрх нь зөрчигдсөн хүүхдийн тоог бууруулах хүрээнд:

Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн иргэдэд үйлчилгээ үзүүлэх Нэг цэгийн үйлчилгээний төвд 2019 оны 06 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн байрны дотор засал болон сантехникийн иж бүрэн засварын ажлыг хийж гүйцэтгэсэн. 2019 оны 11 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болсон 93 иргэнд /хүүхэд-81, насанд хүрсэн иргэн-12/ эрүүл мэнд, боловсрол, хууль эрх зүй, сэтгэл зүй, аюулгүй байдлын хамгааллын үйлчилгээг үзүүлэн ажилласан. Эцэг эх нь архины хамааралтай 0-12 насны 7 хүүхдийг "Бадамлянхуа" асрамжийн төвд дүүргийн Засаг даргын захирамжаар хүлээлгэн өгсөн. Хан-Уул дүүргийн хэмжээнд хараа хяналтгүй болон хараа хяналт сул хүүхдийг илрүүлэх, илэрсэн хүүхдийг хамгаалах, хариу үйлчилгээ үзүүлэх, хүүхдийн бүртгэлийн мэдээллийн санд оруулах, гэр бүлд нь эргэн нэгтгэх зорилгоор "Илрүүлэлт" аян өрнүүлж, дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй цахим тоглоомын газрууд, томоохон шөнийн цэнгээний

газрууд, голын эрэг, жалга, хогийн цэгүүдэд 3 удаа илрүүлэлтийн арга хэмжээ зохион байгуулж нийт 131 хүүхдийг илрүүлсэн. Үүнээс: Хан-Уул дүүргийн 61 хүүхэд, бусад дүүргийн 70 хүүхэд тус тус илэрснийг эцэг эх, асран хамгаалагч нарт нь хүлээлгэн өгч, бусад дүүргийн хүүхдүүдийн мэдээллийг харьяалах дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтэст хүргүүлсэн. Нийт 239 эцэг, эхэд Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хуулиудыг танилцуулан, зөвлөмж мэдээлэл өгч ажилласан.

1.5 Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан тухайн байгууллагаас гүйцэтгэсэн ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

Нийслэлийн Засаг дарга болон Хан-Уул дүүргийн Засаг даргын хооронд Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны “Аз жаргалтай хот” хөтөлбөр, Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх үр дүнгийн гэрээний төслийг боловсруулан нийслэлийн Засаг даргын Орлогч, төслийн удирдагч нар болон НЗДТГ-ын хэлтэс, албадын дарга, холбогдох мэргэжилтнүүдээс саналын хуудсаар санал авч, гэрээний төслийг 02 дугаар сарын 02-нд НЗДТГ-ын СТСХ-т хүгүүлж, 2019 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр гэрээ байгуулагдсан.

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны “Аз жаргалтай хот” хөтөлбөрөөс дүүрэг хариуцан хэрэгжүүлж буй 9 төсөл арга хэмжээний хэрэгжилтийг тооцож ЗДТГ-ын даргын 2019 оны 06 сарын 05-ны өдрийн 06/1214 тоот албан бичгээр НЗДТГ-ын ХШҮ-ний хэлтэст хүргүүлсэн. Эхний хагас жилийн байдлаар 53.3 хувь, 3-р улирлын хэрэгжилт 73.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн биелэлтийг 2019 оны 01 сарын 05-ны өдрийн дотор хүргүүлэхээр бэлтгэж байна.

1.6 Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгасан ажлын явц, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

Нийслэлийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн дүүрэгт хамаарах 37 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 51 арга хэмжээ бүхий нарийвчилсан төлөвлөгөө боловсруулан дүүргийн Засаг даргаар хянуулж, НЗДТГ-ын Санхүү төрийн сангийн хэлтэст хүлээлгэн өгсөн. Нарийвчилсан төлөвлөгөөний биелэлтийг 2019 оны 1 дүгээр улирлын байдлаар тооцож, НЗДТГ-ын Хяналт шинжилгээ-үнэлгээний хэлтэст, /хэрэгжилт 34,3%/ хагас жилийн биелэлтийг тооцож ЗДТГ-ын даргын 2019 оны 06 сарын 05-ны өдрийн 06/1214 дугаар албан бичгээр НЗДТГ-ын ХШҮ-ний хэлтэст тус тус хүргүүлсэн. Эхний хагас жилийн байдлаар 46.6 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийслэлийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг 2019 оны 01 сарын 15-ны өдрийн дотор хүргүүлэхээр бэлтгэж байна.

1.7 Дэд хөтөлбөрт тусгасан, тухайн байгууллагаас гүйцэтгэх ажлын хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

Дүүргийн дэд хөтөлбөр: Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоолоор батлагдсан 5 дэд хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг нэгтгэн ДИТХ-ын Ажлын албанд хугацаанд нь хүргүүлсэн.

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн хурлаар батлагдсан **24** дэд хөтөлбөрийн **129** зорилтын биелэлт эхний хагас жилд **70.2%**, **жилийн эцсийн байдлаар 93.1** хувьтай хэрэгжсэн.

Хөтөлбөрүүдийн хэрэгжилт:

№	Хөтөлбөр	Зорилт	Төсөв / нийт буюу зарцуулсан/	100% /90-100/	70% /50-89/	40% /31-59/	0 % /0-30/	Дундаж хувь
1	Зөв хүүхэд-Зөв ирээдүй	6	250.000.000 24,977,500			6		40%
2	Аз жаргалтай гэр бүл	7	150.000.000 50.182.000	4	-	-	-	60%
3	Ахмадаа дээдэлье	3	100.000.000 9.000.000		1	4		35%
4	Хороодын хөгжил -Төрийн үйлчилгээ	7	150.000.000 33.517.275			7		40%
	Нийт	23	650.000.000 117.676.275	4	1	17	-	50.%

"ХОРООДЫН ХӨГЖИЛ-ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭ" ХӨТӨЛБӨР

"Хороодын хөгжил-Төрийн үйлчилгээ" хөтөлбөрийн 2018, 2019 оны хэрэгжилтийн байдалд дүн, шинжилгээ хийж, дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон дүүргийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор уг хөтөлбөрийн зорилтын хүрээнд санхүүжүүлэх шаардлагатай ажлын жагсаалтын санал боловсруулан Салбар зөвлөлийн хуралд танилцуулсан.

Эхний хагас жилийн байдлаар "Хороодын хөгжил-Төрийн үйлчилгээ" хөтөлбөрийн Салбар зөвлөлийн хурлын бэлтгэл ажлыг ханган **5** удаа зохион байгуулсны зэрэгцээ Салбарт зөвлөлд ирүүлсэн нийт **9** төслийг хэлэлцүүлэн дэмжигдсэн төслүүдийг дүүргийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанд оруулж, холбогдох шийдвэрийг гаргуулсан.

2019 оны эхний хагас жилд "Хороодын хөгжил-Төрийн үйлчилгээ" хөтөлбөрийн хүрээнд **6** төслийг **33.517.275** төгрөгөөр санхүүжүүлэн хэрэгжүүлээд байна.

Дүүргийн иргэд оршин суугчдад үр өгөөжтэй төсөл, хөтөлбөр боловсруулж төр, хувийн хэвшлийн түншлэлээр хэрэгжүүлэх зорилгоор "Сайн хөрш ба Эко гудамж" төслийг боловсруулаад байна.

"ЗӨВ ХҮҮХЭД-ЗӨВ ИРЭЭДҮЙ" ХӨТӨЛБӨР

1.8 Дүүргийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл:

Дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2019 оны биелэлт эхний хагас жилийн биелэлт 48.7 хувь, жилийн эцсийн байдлаар 93.4 хувьтай биелсэн байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн шууд захирагчтай байгуулах 2019 оны үр дүнгийн гэрээний загварыг шинэчлэн боловсруулж, 22 хэлтэс, албадаас гэрээний төслийг хянаж, хүлээн авч, гэрээнд гарын үсэг зуруулан албажуулан хэлтсүүдэд хүргүүлсэн. Мөн төсвийн ерөнхийлөн захирагчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн Захирал, Эрхлэгчтэй байгуулах 2019 оны үр дүнгийн гэрээний төсөлд дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрөөс холбогдох арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх санал боловсруулж тусгуулсан.

Дүүргийн Засаг даргын 2019 оны А/10 дугаар захирамжаар 2019 оны 01 дүгээр сарын 16, 17, 21-ний өдрүүдэд төсвийн ерөнхийлөн захирагч, Засаг даргын дэргэдэх 22 хэлтэс, албадын төсвийн шууд захирагчтай байгуулсан 2018 оны үр дүнгийн гэрээ дүгнэх арга хэмжээ зохион байгуулсан.



Үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлсэн ажлуудаас:

2019 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн байдлаар “Бүх нийтийн их цэвэрлэгээг 11 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 6693 аж ахуйн нэгж байгууллага, 42047 хүнийг хамруулан, гадна орчны цэвэрлэгээг хийлгэж 853.7 тонн хог хаягдлыг 306 рейсээр төвлөрсөн хогийн цэгт ачиж тээвэрлэсэн. 2019 оны 12 дугаар сарын 07-ны өдөр ээлжит бүх нийтийн их цэвэрлэгээг зохион байгуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.



“ХОГГҮЙ ХАН-УУЛ 2019” АЯНЫ ХҮРЭЭНД

Хан-Уул дүүргийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн А/112 дугаар захирамжаар “Хоггүй Хан-Уул 2019” аяныг 04 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн зохион байгуулсан. Аяны хүрээнд нийт 1578.6 тн хог хаягдлыг цэвэрлэж, тээвэрлэсэн.

Хүснэгт. "Хоггүй Хан-Уул 2019" аяны хүрээнд зохион байгуулсан цэвэрлэгээ

№	Байгууллагын нэр	Оролцсон хүний тоо	Цэвэрлэсэн талбайн байршил	Гарсан хогны хэмжээ, тн
1	2	3	4	5
"Их цэвэрлэгээ 90 минут" арга хэмжээ				
1	Төрийн болон хувийн хэвшлийн 1223 ААНБ	13076	Дүүргийн нийтийн эзэмшлийн зам талбай /178065 м²/	127.7
Зуслан ногоон бүсийн их цэвэрлэгээ				
2	Төрийн болон хувийн хэвшлийн 879 ААНБ	5010	Туул, Дунд, Түргэний гол дагуу /2020.5 мянган м²/	109.4
"Туул голоо цэвэрлэх хөдөлгөөн"-д нэгдсэн ААНБ				
3	Улаанбаатар буян ХХК	120	Яармагийн гүүрнээс баруун тийш Туул гол дагуу 3.0 км	8.0
4	Шинэ монгол сургууль	30	Яармагийн гүүрнээс зүүн тийш Туул гол дагуу 2.0 км зайд	3.0
5	Транскапитал ББСБ	70	2 дугаар хорооны нийтийн эзэмшлийн зам талбайд	2.0
6	Төрийн банк	500	Маршаллын гүүрнээс Сонсголониин гүүр хүртэл Туул гол дагуу	
7	Есөн шижир ББСБ	27	Яармагийн гүүрнээс баруун тийш Вива сити хотхоны баруун зах хүртэл	1.5
8	Иргэний нисэхийн Ерөнхий газар	70	Туул гол дагуу 10 дугаар хорооны нутаг дэвсгэрт	4.0
9	Project zerodes төслийн хамт олон	8	Туул гол	0.5
10	ХААИС-ын Оюутны холбоо МИДСК, VLP сайн дурын олон улсын байгууллага	70	Туул голын эрэг дагуу, Зайсангийн гүүр орчим	2.5
11	Иргэн Чинзориг	1	Яармагийн гүүрнээс Зайсангийн гүүр хүртэл	
Үүсмэл болон хур хог хаягдлын цэвэрлэгээ				
1	ТОХИЖИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ ОНӨААТҮГ		12-р хороо, 8-р хэсгийн үүсмэл цэгийн цэвэрлэгээ	2,7
2			13-р хороо, чөтгөрийн хонхорын үүсмэл цэгийн устгал	3,1
3			14-р хороо, 1, 4-р хэсгийн ойр орчмын жалга, төв замын 2 талын үерийн суваг, далан	1,2
4			16-р хороо, төв зам дагуух үерийн далан цэвэрлэгээ	0,7
5			13-р хороо, үхсэн малын сэг зэм	43,7
6			14-р хороо, үхсэн малын сэг зэм	
7			11-р хороо, 4-р хэсгийн дунд байрлах үүсмэл цэг	6
8			13-р хороо, хуучин уурын зуухны хажууд үүссэн хур хогны судалгаа.	3,1
9			9-р хороо, бурхантын 9-р гудамжны дээд жалга, 107-ийн жалга	2,4
10			9-р хороо, бурхантын дээд жалганы үүсмэл хогийн цэвэрлэгээ	35,6

11	"ХАН-УУЛ АГРО" ОНӨААТҮГ	10-р хороо, нисэхийн хашааны баруун талаас жаргалант эко хүртэлх талбайн хур хогийн цэвэрлэгээ	73,8
12		10-р хороо, Морингийн давааны доод талын жалга	75,1
13		4-р хорооны нийтийн эзэмшлийн зам талбай	557,8
14		5-р хорооны нийтийн эзэмшлийн зам талбай	290,95
15		6-р хорооны нийтийн эзэмшлийн зам талбай	121,65
16		7-р хорооны нийтийн эзэмшлийн зам талбай	102,15

"Хоггүй Хан-Уул 2019" аяны хүрээнд:

Бүх нийтийн их цэвэрлэгээг 2 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 2102 ААНБ, 18086 хүн оролцсон. Нийт 2198,6 мянган м.кв талбайг цэвэрлэж 237,1 тн хог хаягдлыг ачиж тээвэрлэсэн.



"Улаанбаатар буян" ХХК ЗДТГ-тай хамтарч "Туул голоо цэвэрлэх" хөдөлгөөнийг эхлүүлсэн. Тус хөдөлгөөнд 10 байгууллага, 1 иргэн 871 хүний бүрэлдэхүүнтэй оролцож Туул гол дагуу 22,0 тн хог хаягдлыг цэвэрлэсэн.



Дүүргийн 4, 5, 6, 7, 8 дугаар хороодын нийтийн эзэмшлийн гудамж, талбайн 17 байршилд хуримтлагдсан 1319,9 тн хог хаягдлыг бүрэн цэвэрлэсэн.



Нийслэлийн Мал эмнэлгийн газар, дүүргийн Мал аж ахуйн тасагтай хамтарч 2019 оны 04 дүгээр сарын 16, 17-ны өдрүүдэд 13, 14 дүгээр хороонд үхсэн 83 тооны малын сэг зэмийг устгаж, ариутгах арга хэмжээ авч ажилласан.



Иргэдэд хөрсний бохирдлын талаар мэдээлэл, сурталчилгаа хүргэх, нүхэн жорлонгийн стандартыг танилцуулах, хотын суурьшлын бүсийн хөрсний бохирдлыг бууруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Эрүүл хөрс – Эрүүл орчин” аяныг зохион байгуулж ажилласан. Аяны хүрээнд дүүргийн 1, 2, 3, 4, 5, 6, 11, 15 дугаар хороодын хогийн цэг, ил задгай бие зассан булан тохой, бохирын худаг хальсан зэрэг хөрсний бохирдол ихтэй нийтийн эзэмшлийн зам талбайн 69 байршилд хэсэгчилсэн ариутгал халдваргүйжүүлэлт хийх ажлыг зохион байгуулсан.



Иргэдэд хөрсний бохирдлын талаар мэдээ, мэдээлэл өгөх “Хөрсөө хамгаалъя” өдөрлөгийг 06 дугаар сарын 06-ны өдөр 9, 10, 16 дугаар хороод /Нисэхийн эцсийн автобусны эцэс/, 06 дугаар сарын 07-ны өдөр 12, 13, 14 дүгээр /Биокомбинат/ хороонд тус тус зохион байгуулсан.

Аяны хүрээнд нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбай, хогийн цэг орчмын **673945 м.кв** талбай, гэр хорооллын айл өрхийн **13494** ширхэг нүхэн жорлон, бохирын цооногийг ариутган халдваргүйжүүлж хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээ авч ажилласан.



График. Ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлын тоо хэмжээг сүүлийн 3 жилийн харьцуулсан үзүүлэлт



Дүүргийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/154 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулан 2 удаа хуралдаж энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тариф, дүүргийн нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг иргэнээр тооцсон. Урьдчилсан дүнгээр энгийн хаягдлыг цуглуулж, тээвэрлэх нэгж тариф 28352.72, нэг иргэнд ноогдох хог хаягдлын хураамж 1395.68 төгрөг гарсан бөгөөд тогтоолын төслийг бэлтгэж байна.



Нийслэл, дүүрэг, орон нутгийн 950.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хог тээврийн 5 автомашин, 1 ширхэг авто грейдер, 1 ширхэг ковшоор хог хаягдлын үйлчилгээний байгууллагын парк шинэчлэлт хийгдсэн.



Хог хаягдлыг ангилан ялгах чиглэлээр:

"Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулж, ангилан ялгаж хэвшье" аяны хүрээнд 1,2,3 дугаар хороонд байгуулсан ангилагдсан, дахивар хог хаягдлыг тээвэрлэх 13 цэгийн үйл ажиллагааг сайжруулж хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулсан. Эрүүл мэндийн төвийн гадна талбайд бага оврын ангилан ялгах 3 өнгийн хогийн савыг шинээр суурилуулсан.

2019 оны 05 дугаар сарын 30-ны өдөр Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албатай хамтарч сурагчдад хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах чиглэлээр мэдлэг олгох "Эко аялал"-ыг 2 удаа зохион байгуулсан.



Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, ангилан ялгах, дахин ашиглах, талаарх иргэдийн мэдлэг, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Өөрт хэрэггүй зүйлээ хэрэгтэй нэгэндээ өгчгөө" уриатай хуучин эд зүйлсээ худалдах, үнэгүй өгөх "Өгөөмөр өдөр" өдөрлөгийг 2019 оны 06 дугаар сарын 09-ний өдөр зохион байгуулсан. Тус өдөрлөгт Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс албад, хороод, төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, Нэгдсэн эмнэлэгийн ажилтан албан хаагчид, иргэд хэрэглэх боломжтой хүүхдийн тоглоом, хуучин болон шинэ хувцас, тавилга, цахилгаан бараа, багаж, ном, бичгийн хэрэгсэл зэрэг нийт 4263 ширхэг эд зүйлсийг хандивлаж оролцсон байна. Өдөрлөгийн үеэр нийт 157 750 төгрөгийн борлуулалт хийгдсэн бөгөөд энэхүү орлогыг Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөх сайн үйлсэд хандивласан.



2019 оны 10 дугаар сарын 08-ны өдөр "Каритас Чех Репаблик" олон улсын байгууллагатай хамтарч хог хаягдлын менежмент, хог хаягдлыг дахин боловсруулах, барилгын хог хаягдал түүний дахин боловсруулалт, барилгын салбарын нөөцийн үр ашигтай байдал, тогтвортой цэвэр үйлдвэрлэл, Монгол дахь хог хаягдлыг дахин боловсруулах өнөөгийн нөхцөл байдал болон холбогдох хууль эрх зүйн орчны талаар мэдээлэл олгох семинарыг зохион байгуулсан.



Нийслэлийн Онцгой комиссын "Шар усны үерийн усны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай" 2019 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 01, Хан-Уул дүүргийн Засаг дарга бөгөөд Онцгой комиссын даргын "Үерийн усны аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг эрчимжүүлэх тухай" 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 01 дүгээр албан даалгаврын дагуу дүүргийн нутаг дэвсгэр дэх үерийн ус зайлуулах байгууламжуудын ашиглалтын байдалд хяналт шалгалт хийх, тэдгээр хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэх, иргэдэд мэдээлэл сэрэмжлүүлэг хүргэх, хэвийн үйл ажиллагааг хангахад чиглэсэн үйл ажиллагааг 04 дүгээр сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд зохион байгуулсан.

2019 оны 03 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 14, 15, 16 дугаар хороодын хөрсний ус зайлуулах далан суваг, авто замын доогуурх ус гадагшлуулах суваг дотор хуримтлагдсан хог хаягдлыг цэвэрлэх ажлыг зохион байгуулсан. Нийт 38.3 тн хог хаягдлыг ачиж тээвэрлэсэн.



Дүүргийн төсвийн 60.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 6, 7 дугаар хорооны голын засмал замын гадаргын ус зайлуулах шугам татах ажлын төндөр 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр зарлагдсан, гүйцэтгэгч сонгон шалгаруулах шатандаа байна.

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны "Их цэвэрлэгээний хуваарь батлах тухай" 01 дүгээр тушаал, дүүргийн Засаг даргын 05 дугаар сарын 21-ний өдрийн А/191 дүгээр захирамжийн дагуу "Шарилжуй Улаанбаатар 4" аяныг дүүргийн хэмжээнд нийт 1118 аж ахуйн нэгж байгууллага, 5192 ажилтан, албан хаагчид, иргэдийн бүлгийг хамруулан 2 үе шаттайгаар зохион байгуулж давхардсан тоогоор 692175 м² талбайн 343.2 тн шарилж, хөл газрын ургамал, хог хаягдлыг цэвэрлэсэн.

Аяны хүрээнд дүүргийн Хөдөлмөр халамжийн үйлчилгээний хэлтэстэй хамтарч ажилгүй, хөдөлмөрийн чадвартай иргэдийг хамруулан иргэдийн "Эко ногоон бүлэг"-ийг байгуулж нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн шарилж, хөл газрын ургамлыг тайрч, танах ажилд оролцуулан түр ажлын байраар хангаж ажилласан. Тус бүлэг нь нийт 30 хүний бүрэлдэхүүнтэйгээр 66288 м² талбайн шарилж, хөл газрын ургамлыг цэвэрлэж устгасан.

Бүдүүвч. Аяны хүрээнд цэвэрлэсэн талбайн хэмжээ

№	Байгууллага	Талбай, м ²	Цэвэрлэгээнээс гарсан шарилж, хог хаягдал тн
Аяны нэгдүгээр үе шатны хүрээнд			
1	Нэгдсэн бүх нийтийн их цэвэрлэгээ /иргэд, ААНБ/	40163	185.5
2	ТҮТ ОНӨААТҮГ	203000	21.3
3	"Хан-Уул Агро" ОНӨААТҮГ	33000	15.5
4	"Эко ногоон бүлэг"	14620	4.5
Аяны хоёрдугаар үе шатны хүрээнд			
5	Нэгдсэн бүх нийтийн их цэвэрлэгээ /иргэд, ААНБ/	134576	76.7
6	ТҮТ ОНӨААТҮГ	192048	19.5
7	"Хан-Уул Агро" ОНӨААТҮГ	23100	13.4
8	"Эко ногоон бүлэг"	51668	6.8
Нийт		692175	343.2



Хог тээвэрлэлтийн талаар: Тохижилт Үйлчилгээний төв ОНӨААТҮГ, Хан-Уул агро ОНӨААТҮГ дүүргийн 2019 оны байдлаар 21 хорооны аж ахуйн нэгж байгууллага, гэр болон орон сууц хорооллын нийт 44741.04 тн хог хаягдлыг 11218.9 рэйсээр /Хан-Уул Агро ОНӨААТҮГ-ын тайлангаар/ тээвэрлэсэн.

Зураг. Гэр хорооллын айл өрхийн **25797.9 тн**, орон сууц хорооллын **11218.9 тн**, ААНБ-ын **10120.11 тн** хог хаягдлыг тээвэрлэлээ.



Бүдүүвч. 2019 оны хог тээвэрлэлт /тн/ 2018 оны мөн үетэй харьцуулсан үзүүлэлт



Хог хаягдлын гэрээ: 2019 оны 11 дүгээр сарын байдлаар 7,982,500 төгрөгийн үнийн дүн бүхий 89 аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдал ачиж тээвэрлэх гэрээг шинээр болон сунгалтаар байгуулсан байна.

Иргэдийн бүлэг: Цэвэрлэгээ үйлчилгээний иргэдийн бүлэг хороодын авто машин орж ачилт хийх боломжгүй, өндөрлөг хэсэг, намаг шавартай хэсэг, хад асгатай болон гуу жалгатай газруудын нийт 621,27 м³ хог хаягдлыг бүрэн цэвэрлэсэн.

Зураг. Иргэдийн бүлгийн цэвэрлэгээ



Дүүргийн нийтийн эзэмшлийн талбайд байршуулсан 8 хогийн савыг будаж, өнгө үзэмжийг сайжруулах ажлыг зохион байгуулсан.



Ногоон байгууламжийн цэвэрлэгээ үйлчилгээний хэлтсийн зам талбайн ажилчдын 40 ширхэг хогийн савыг шинэчилж, хог хаягдлыг ангилан ялгах чиглэлээр иргэдийг уриалсан стикерүүдийг нааж байршуулсан.



"Нэг хот –Нэг стандарт" зорилтын хүрээнд 26 байршилд 6290 м² талбай, "Манай хороо – Миний гудамж" аяны хүрээнд иргэн аж ахуйн нэгж байгууллагууд 4250м² талбай, нийслэл дүүргийн хөрөнгө оруулалтаар 11789 м² талбай явган зам нийт дүүргийн хэмжээнд 16035м² талбайд явган зам шинээр тавьсан байна.



Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Нисэхийн эцсийн автобусны буудлаас Буянт-Ухаа 21 дүгээр гудамж хүртэлх 2.8 км хатуу хучилттай авто зам, Морингийн давааны 1.2 км урт хатуу хучилттай авто замууд хийгдэж ашиглалтад орсон.

Байгаль орчны чиглэлээр: Түгээмэл тархацтай ашигт малтмалын үйл ажиллагаанд түр хугацаагаар хориглох, хяналт шалгалт явуулах тухай дүүргийн Засаг даргын А/77 дугаар захирамж гарч ажлын хэсэг байгуулгдсан. Хүнд даацын тээврийн хэрэгслийн тээвэрлэлтийг газар гэсэлттэй холбогдуулан түр хугацаагаар зогсоохоор шийдвэрлэсэн.



Дүүргийн Замын цагдаа, цагдаагийн хоёрдугаар хэлтсээс 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн Нисэхийн пост, Таван толгойн постуудад цагдаагийн албан хаагчид 24 цагаар хяналт шалгалт хийж ажилласан.

Энэ ажлын хүрээнд нийт 2635 зөрчил илрүүлсэнээс Зөрчлийн тухай хуульд заасны дагуу 2330 жолоочид 32,399,215 сая төгрөгийн торгууль оногдуулсан.



Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар болон Өргөдлийн байнгын хорооны гишүүд дүүргийн 12,13 дугаар хороодод ажиллаж Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч аж ахуйн нэгжүүд тэр дундаа Төв аймгийн "Алтанбулаг" суманд ажиллаж байгаа ашигт малтмал олборлогч байгууллагуудтай уулзаж тулгамдаж буй асуудлуудтай танилцаж харилцан санал солилцсон.



Дүүргийн Засаг даргын нэгдүгээр орлогчоор ахлуулсан ажлын хэсэг 2018 онд нөхөн сэргээлт хийсэн "Эссто" ХХК, "Ядам од" ХХК, "Минжийн хангайн төгөл" ХХК, "Боржигины тал" ХХК, "Очирням" ХХК-ийн үйл ажиллагаатай танилцсан.



Иргэдийн ундны гүний худгийн уснаас шинжилгээ хийсэн талаар:

Ундны усны зориулалттай гаргасан гүний худгуудыг Газарзүй-Геоэкологийн хүрээлэн Усны шинжилгээний лаборатортой хамтарч дүүргийн 9, 10, 11, 12, 13 дугаар хорооны 17 гүний худагнаас бохирдол, хатуулаг, эрдэс бодис, цахилгаанжилтын сорьцын шинжилгээ хийснээс 12 дугаар хороонд байрлах 370 дугаар худгийн ус хатуулаг, бохирдол ихтэй гарсан тул Ус сувгийн удирдах газарт мэдээлж 2,465,000 сая төгрөгийн хэмнэлт хийсэн.



1.9 Дүүргийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт, үр дүнтэй холбоотой мэдээлэл

Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийг холбогдох хэлтэс, албадаас хүлээн авч хэрэгжилт, үр дүнтэй тооцон улирал бүр хугацаанд нь тайлагнаж ажиллалаа. Үндсэн чиглэлийн биелэлт нэгдүгээр улирлын байдлаар 28.3 хувь, хоёрдугаар улирлын байдлаар 50.8 хувь, гуравдугаар улирлын байдлаар 73.3 хувьтай тус тус биелсэн бөгөөд, жилийн эцсийн биелэлтийг ДИТХ-ын ээлжит 7 дугаар хуралдаанаар хэлэлцүүлж 92.4 хувь буюу бүрэн хангалттай үнэлүүлсэн.

Дүүргийн эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж олон нийтэд сурталчлах зорилгоор үндсэн чиглэлийг эмхэтгэн гарын авлага боловсруулж, иргэдэд тараан сурталчилсан.




Үндсэн чиглэлийн хүрээнд хийгдсэн ажлуудаас:

Бүх нийтээр мод тарих өдрийг 5, 10 дугаар сард зохион байгуулж, давхардсан тоогоор 147 өрх, 3122 иргэн, 1229 аж ахуйн нэгж байгууллага хамрагдан нийт 15282 ширхэг мод, бут, сөөг тарьсан.



“Манай хороо- Миний гудамж” аяны хүрээнд 118 аж ахуйн нэгж байгууллага иргэдийн оролцоотой **126243** ширхэг мод бут сөөг, **21420м2** талбайг зүлэгжүүлсэн. Нийт дүүргийн хэмжээд 224229 ширхэг мод бут сөөг шинээр тарьж, 55653 м2 талбайг шинээр зүлэгжүүлсэн.



Сууц өмчлөгчдийн холбооны чиглэлээр: Шинээр СӨХ байгуулахаар ирүүлсэн 19 хүсэлтийн бичиг баримтын бүрдэлд хяналт хийж Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагааны зөвшөөрлийн гэрчилгээг олгож 1, 2, 3, 10 дугаар хорооны нийт 32 Сууц өмчлөгчдийн холбооны үйл ажиллагаанд хяналт шалгалтыг зохион байгуулсан. Үүний үр дүнд, нийслэлийн “Буянт өрх” шилдэг Сууц өмчлөгчдийн холбоог шалгаруулах ажлын хүрээнд 1 дүгээр хорооны “Эрэл-3” Сууц өмчлөгчдийн холбоо нийслэлийн тэргүүний сууц өмчлөгчдийн холбоогоор шалгарсан.



Дүүргийн Засаг даргын 2018 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн “Орон сууцны техникийн хонгилд үзлэг шалгалт явуулах тухай А/370 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 1, 2, 3 дугаар хорооны 44 байрны 178 подволиор үзлэг шалгалт хийж үзэлийн өрөөнд их хэмжээний хог хураасан, цахилгаан шитний өрөө хаалгагүй, архидан согтууралт ихтэй, агааржуулагч цонхгүй бохир орчинд иргэд амьдарч байгаа зөрчлүүдийг илрүүлсэн.

Холбогдох сууц өмчлөгчдийн холбоодод тус зөрчлийг арилгах талаар хугацаатай үүрэг даалгавар өгч ажилласан.



Агаарын бохирдлын чиглэлээр: Нийслэлийн байгаль орчны газар, Монголын Арьс ширний холбоотой хамтран дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг 31 аж ахуйн нэгж байгууллагатай 2019 онд хийж хэрэгжүүлэх ажлын талаар болон "Арьс ширний үйлдвэр орчмын газрын хөрсний хүнд металл, хромын бохирдлыг бууруулах судалгааны ажлын үр дүнг танилцуулах уулзалт семинарыг зохион байгуулж зөвлөмж дүгнэлт гаргасан.



зөвлөмж дүгнэлт:

- ✓ Бохирдол үүсгэгч Аж ахуйн нэгжийн хашааны гаднах шороон замыг бетон зуурмаг, асфальтаар хучих
- ✓ Хашаан доторх сул шороон хөрсийг судалгааны тайланд заасан мод бут сөөг тарьж бохирдлын үүсвэрийг салхи, бороо, хүний хөл, машины дугуйгаар ус хөрс бохирдуулах явдлыг зогсоох
- ✓ Хан-Уул дүүрэгт хүнд металлын бохирдол үүсгэгчид дээрх аргаар бохирдлыг бууруулах ажлыг хэрэгжүүлж эхлэх.
- ✓ Арьс ширний үйлдвэрүүдийн орчмын өнгөн хөрсний болон хөрсний гүний судалгаагаар Хромын /нийт/ бохирдлын хэмжээ хөрсний стандартаар хортой төвшинд байна.
- ✓ Хөдөлгөөнт хромын хэмжээ зөвшөөрөгдөх дээд хэмжээнд байна.
- ✓ Нэмж бохирдол үүсэх явдлыг зогсоох шаардлагатай
- ✓ Нийтийн эзэмшлийн талбайд бохирдсон хөрсийг органик бүтээгдэхүүнээр боловсруулж хромын хоруу чанарыг бууруулах дээр нь хүнд металлыг татаж хуримтлуулж саармагжуулах чадвартай нь нотлогдсон ургамал, бут мод тарих замаар бохирдлын үүсгэврийг дунд урт хугацаанд бууруулах

Зөвлөмжийн дагуу Нийслэлийн Байгаль орчны газраас дүүргийн 3 дугаар хорооны 43 дугаар байр, 3,4 дүгээр байрнуудын гадна хөрсний бохирдол ихтэй байршилд хөрсний бохирдлыг саармагжуулах чиглэлээр ногоон байгууламж байгуулсан.



Дүүргийн төсөвт байгууллагуудын халаалтыг төвлөрсөн халаалтын системд холбох ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.

Дүүргийн төсөвт байгууллагуудын халаалтыг төвлөрсөн халаалтын системд холбох ажлын хүрээнд 5, 6, 7, 8, 9, 12, 13, 14, 16 дугаар хороодын байр, Нийслэлийн ерөнхий боловсролын 60, 118, 41, 26, 10 дугаар сургууль, 145, 29, 71, 185, 209, 73, 190, 144 дүгээр цэцэрлэгийн судалгааг Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах газарт хүргүүлсэн. УБЗАА-тай хамтарч төрийн өмчийн 100 кВт-аас дээш хүчин чадалтай халаалтын зууханд шүүлтүүр суурилуулах судалгаа хийж, 24 байгууллагыг хамруулснаас төрийн өмчийн 3, хувийн хэвшлийн 5 байгууллагад яндангийн шүүлтүүр суурилуулсан.

Дүүргийн 7, 8 дугаар хороо, 60, 118 сургууль, 209, 73 дугаар цэцэрлэг төвлөрсөн халаалтанд шилжихэд бэлэн болсон. 9 дүгээр хорооны Аяут өрхийн эмнэлэг цахилгаанд 10-р хорооны өрхийн эмнэлэг төвлөрсөн халаалтад тус тус холбогдсон. 5, 6 хороонд магистраль шугамыг босоо чиглэлд 630 голчтой хос шугам 1,2 км, хөндлөн огтлолд 400 голчтой шугам 2,5 км газарт Улсын төсвийн хөрөнгөөр шинээр хийгдсэн.

ХҮНС, ХУДАЛДАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР:

Үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр: Орчин үеийн дэвшилтэд техник технологи нэвтрүүлсэн үйлдвэрүүд болох "АПУ" ХК, "Витафит" ХК, хөнгөн үйлдвэр "Их эргэлт" ХХК, "Мон тулга" ХХК, "Кашмер холдинг" ХХК-иудын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах аяллыг 5 удаа зохион байгуулж, давхардсан тоогоор 412 иргэн аж ахуйн нэгжийг хамруулсан.



Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих чиглэлээр: Монгол фермер худалдааны төвтэй "Хамтран ажиллах гэрээ"-байгуулж, "Хороодын хөгжил-Төрийн үйлчилгээ" дэд хөтөлбөрийн санхүүжилтээр тус төвд ажиллах "Борлуулалтын төв"-ийн түрээсийн асуудлыг шийдвэрлэж, тохижилтын ажлыг Нийслэлийн шинжлэх ухаан Үйлдвэрлэл инновацийн газартай хамтран гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Борлуулалтын төвд бүтээгдэхүүн борлуулах хүсэлтэй 58 худалдаа эрхлэгчдийн бүртгэсэн.



2019 оны 06 дугаар сарын 07-ны өдөр Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн танхимтай хамтран “Жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдийн нээлттэй өдөрлөг санхүүжилтын нэгдсэн форум” арга хэмжээг зохион байгуулсан. Тус форумд МҮХАҮТ, ХХААХҮЯ-ны ЖДҮХСан, Бизнес Эрхлэгч Эмэгтэйчүүдийн Төв, Зээлийн батлан даалтын сан болон Хас банк, Голомт банк, Улаанбаатар хотын банкны төлөөлөл, Хан-Уул дүүргийн 100 гаруй үйлдвэрлэл эрхлэгчид оролцсоноос 10 үйлдвэрлэл эрхлэгч инноваци нэтрүүлсэн үйлдвэрлэлийн танилцуулга хийж, бүтээгдэхүүнээр үзэсгэлэн гарган харилцан туршлага солилцсон.



Хүнс хөдөө аж ахуйн салбарын эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэх чиглэлээр:

Дүүргийн алслагдсан хороод буюу 12, 13, 14 дүгээр хороонд эрчимжсэн мал аж ахуйг төрөлжүүлэн хөгжүүлэх зорилтын хүрээнд жишиг фермерүүдийн үйл ажиллагаатай танилцах, харилцан туршлага судлуулах зорилгоор аялал-сургалтыг зохион байгуулж, оролцсон 40 гаруй малчид, фермерүүдэд хөдөө аж ахуйн салбарт төрөөс баримталж буй бодлого, шийдвэр, дүүргийн ЗДТГ-аас хөдөө аж ахуйн салбарт ажиллагсдыг дэмжих чиглэлээр хийгдсэн ажлуудын талаар мэдээлэл хийж, Төв аймгийн Ар хуст суманд байрлах “Нүүдэлчин агро”, Баяндэлгэр суманд байрлах “Хишигтэн нүүдэлчин” фермийн үйл ажиллагаатай танилцуулж, харилцан туршлага солилцож, мэргэжилтнүүдийн заавар зөвлөгөөг өгч ажилласан.



ХХААХҮЯ-ны ЖДҮХС-ын урт хугацаатай, хөнгөлөлттэй зээлийн журам, төсөл бичих арга зүй сэдэвт сургалт, уулзалтыг малчин, ферм эрхлэгч 51 иргэнд зохион байгуулсан.

Дүүргийн Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төвөөр дамжуулан төслийн зээлийн талаар 500 гаруй иргэн, аж ахуйн нэгжид мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгч, 127 төслийн материал хүлээн авч ХХААХҮЯ-нд хүргүүлсэн.

Газар тариалан эрхэлдэг иргэн аж ахуйн нэгжийн тариалалтад дэмжлэг үзүүлэн шар лууван 30кг, хүрэн манжин 15кг, шар манжин 5кг, ногоон сонгино 2кг нийт 52кг хүнсний ногооны үрийг 4,5,6,7,8,9,10,11,12,13,14 дүгээр хороодоор дамжуулан олгож үйл ажиллагааг дэмжин ажилласан.

Органик хүнс, түүний ач холбогдлыг сурталчлах ажлын хүрээнд "Хүлэмжинд хүнсний ногоо тарихын ач холбогдол, хүлэмжийн хөрс боловсруулалт" сэдэвт онол дадлагын сургалт зохион байгуулж, 41 иргэнийг хамруулж, 6 төрлийн хүнсний ногооны үр олгосон.

"Ургамлын гаралтай түүхий эд хүнсний бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл, хүлэмжийн эрсдлийн даатгалын талаар 3 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 168 иргэнд сургалт зохион байгуулж, гарын авлагаар хангаж ажилласан.

Хөдөө аж ахуйн салбарын 2019-2020 оны өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах ажлын хүрээнд дүүргийн Засаг даргын 2019 оны А/289 дугаар захирамжаар хөдөө аж ахуйн салбарын 2019-2020 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах ажлыг зохион байгуулах ажлыг хэсгийн бүрэлдэхүүн, ажлын төлөвлөгөөг баталж, хэрэгжилтийг ханган ажилласан. Дүүргийн 12, 13, 14 дүгээр хорооны мал бүхий иргэд, аж ахуйн нэгжийн бэлтгэвэл зохих өвс тэжээлийн төлөвлөгөөг хороодод хүргүүлсэн. Мөн өвс тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх төсвийн тооцоог гаргаж, шаардагдах санхүүгийн эх үүсвэр 50.0 сая төгрөгийг 2020 оны дүүргийн төсөвт тусгуулахаар санал хүргүүлсэн. Дүүргийн аюулгүйн нөөцөд өвс 29,5тн, тэжээл 7,4 тн-ыг тус тус бэлтгэхээр төлөвлөсөн.

Аялал жуулчлалын чиглэлээр: Дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, аялагчдад дүүргийн байгалийн үзэсгэлэнт газрууд, түүх соёлын дурсгалт газруудын талаар нэгдсэн мэдээлэл олгох, зөв зохистой аялах талаар зөвлөгөө мэдээлэл өгөх "Хан-Уул дүүргийн аялал жуулчлалын маршрут" брошур 500 ширхэгийг бэлтгэн иргэдэд сурталчилж, дүүргийн түүхийн дурсгалт газруудыг танилцуулах аялалыг 11 сарын 21-ний өдөр зохион байгуулж 53 иргэн хамруулсан.



НИЙГМИЙН ХӨГЖИЛ ХАМГААЛЛЫН ЧИГЛЭЛЭЭР:

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

2.1 Засгийн газрын тогтоол, Засгийн газрын хуралдааны тэмдэглэл, Ерөнхий сайдын захирамж, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Нийслэлийн

Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, Нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар, Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн хуралдаанаас тэмдэглэлээр өгсөн үүрэг, даалгаврын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл:



Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89, 2019 оны 37 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2017 оны А/335 дугаар захирамжийн хавсралтад заасан журмын дагуу Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгийн үйл ажиллагааны тайланг 7 хоног, сар, хагас, бүтэн жилээр нэгтгэн боловсруулж, холбогдох албан тушаалтад танилцуулан баталгаажуулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст тайлант хугацаанд нь цахимаар болон албан бичгээр тус тус хүргүүлсэн.

Тогтоол шийдвэрийн заалтуудыг улирал тутам хяналтад авч ажилласан бөгөөд 2019 оны

- ❖ I дүгээр улиралд **21** тогтоол шийдвэрийн **76** заалтын биелэлт-**30%**
- ❖ II дугаар улиралд **14** тогтоол шийдвэрийн **54** заалтын биелэлт-**58.1%**
- ❖ III дугаар улиралд **4** тогтоол шийдвэрийн **19** заалтын биелэлт-**74.1%**

2019 оны жилийн эцсийн байдлаар биелэлтийг тооцож мэдээлэх **17** тогтоол шийдвэрийн **43** заалтын биелэлтийг нэгтгэн, хяналт шинжилгээ үнэлгээ хийлгэн, батлуулж, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэст хугацаанд нь 2019 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 04/2400 дугаар албан бичгээр хүргүүлсэн. /**Биелэлтийн дундаж-90.1%**/

ТОГТООЛ, ШИЙДВЭР	ТОО	ЗААЛТ	ҮНЭЛГЭЭ
2019 оны жилийн эцсийн байдлаар			
УИХ-ын байнгын хорооны тогтоол	1	1	100%
Ерөнхийлөгчийн зарлиг	2	3	85%
Засгийн газрын тогтоол	7	20	84.4%
Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	3	3	80%
НИТХ-ын Хурлын тогтоол	2	2	100%
НИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол	2	14	89.2%
ДҮН	17	43	86.5%

<http://monitoring.ub.gov.mn/> програмаар 2019 оны жилийн эцсийн байдлаар тайлагнах нийт 10 тогтоол шийдвэрийн 49 заалтын биелэлтийг нэгтгэн, хугацаанд нь програмаар тайлагнасан. /Биелэлтийн дундаж-96.5%/

Хяналтын үндэс	Хяналтын үндэс	Хяналтын үндэс	Хяналтын үндэс	Хяналтын үндэс	Хяналтын үндэс
1	Засаг дарга	2019-01-01	2019-01-01	2019-01-01	2019-01-01
2	Засаг дарга	2019-01-01	2019-01-01	2019-01-01	2019-01-01
3	Засаг дарга	2019-01-01	2019-01-01	2019-01-01	2019-01-01
4	Засаг дарга	2019-01-01	2019-01-01	2019-01-01	2019-01-01
5	Засаг дарга	2019-01-01	2019-01-01	2019-01-01	2019-01-01
6	Засаг дарга	2019-01-01	2019-01-01	2019-01-01	2019-01-01
7	Засаг дарга	2019-01-01	2019-01-01	2019-01-01	2019-01-01
8	Засаг дарга	2019-01-01	2019-01-01	2019-01-01	2019-01-01
9	Засаг дарга	2019-01-01	2019-01-01	2019-01-01	2019-01-01
10	Засаг дарга	2019-01-01	2019-01-01	2019-01-01	2019-01-01

Захирамжлалын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх ажлын хүрээнд дүүргийн дэргэдэх хэлтэс, албадад 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдөр сургалт зохион байгуулах 04/940 дүгээр албан бичгийг хүргүүлж 2019 оны 05 дугаар сарын 24-ний өдөр тогтоол шийдвэрийн биелэлтийг тайлагнадаг нийт 20 албан хаагчдад арга зүйн зөвлөгөө, сургалтыг зохион байгуулсан.



Монгол Улсын Засгийн газраас зарласан "Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил"-ийн хүрээнд Хан-Уул дүүрэг хариуцан хэрэгжүүлэх 15 зорилтын 32 арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан, 2019 оны жилийн эцсийн биелэлтийг нэгтгэн, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтэст 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн 04/2390 дугаар албан бичгээр хугацаанд нь тайлагнасан. /Биелэлтийн дундаж-87.4%/

2019 оныг "Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил" болгон зарласантай холбогдуулан Хан-Уул дүүрэг хариуцан хэрэгжүүлэх 40 ажлыг төлөвлөн улирал бүр тайлагнан ажилласан бөгөөд

- I дүгээр улирлын биелэлт-34.6%
- II дугаар улирлын биелэлт-56.6%
- II дугаар улирлын биелэлт-78.6%
- 2019 оны жилийн эцсийн байдлаар төлөвлөгөөний биелэлтийг гарган, батлуулж 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдрийн 04/2446 дугаар албан бичгээр Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт болон Улаанбаатар хотын захирагчийн ажлын албанд тус тус хүргүүлсэн. /Биелэлтийн дундаж-91.8%/

ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХҮРЭЭНД ХИЙСЭН АЖЛУУДААС:

Төрийн одон медаль: Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 05 дугаар сарын 23-ны өдрийн 100 дугаар зарлигаар дүүргийн хэмжээнд 31 эх "Алдар эх" 1 дүгээр зэргийн одонгоор, 457 эх "Алдар эх" 2 дугаар зэргийн одонгоор тус тус шагнагдсан.

Төрийн дээд одон, медалиар шагнуулахаар нэр дэвшүүлсэн иргэдийн материал, тодорхойлолтыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хурлын 10 удаагийн тогтоолоор 592 иргэний материалыг дэмжүүлж, нийт 174 иргэн шагнагдсан.

Хүнс, худалдаа үйлчилгээний чиглэлээр: Монгол улсын Ерөнхийлөгчийн 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 104 дугаар зарлигийн хүрээнд Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль тогтоомжид өөрчлөлт оруулах талаар 8 дугаар сар, 11 дүгээр саруудад дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж байгууллага, хороодын иргэд, Цагдаагийн 1,2 дугаар хэлтсийн албан хаагчдаас тус тус 10 асуумж бүхий санал асуулга авч санал асуулгаас гарсан дүгнэлт, тоон мэдээлэл, нэмэлт саналуудыг УБ хотын 3АА-нд тус тус хүргүүлсэн.

Асуулгад нийт 1271 иргэн саналаа өгсөн. Мөн дүүргийн нутаг дэвсгэрт архи, согтууруулах ундаа худалддаг болон түүгээр үйлчилдэг 80 гаруй аж ахуйн нэгжид Монгол улсын Ерөнхийлөгчийн 104 дүгээр зарлигийг танилцуулж, хэлэлцүүлэг зохион байгуулсан.

Бүх төрлийн 0.0035 мм болон түүнээс нимгэн, нэг удаагийн нийлэг хальсан уутыг худалдаа, үйлчилгээнд сав, баглаа боодлын зориулалтаар импортлох, үйлдвэрлэх, хэрэглэхийг 2019 оны 03 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хориглож байгаатай холбогдуулан "Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай" Засгийн газрын 2018 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн 189 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангаж, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлж ажиллах талаар 2019.01.09-ний өдрийн 06/55, 06/57 дугаар албан бичиг, "Нэг удаагийн нийлэг хальсан уутыг хориглох тухай шийдвэрийг хэрэгжүүлэх зөвлөмж"-ийг 340 аж ахуйн хүргүүлэн хяналт тавин ажиллаж байна..



Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд "Худалдаа үйлчилгээний байгууллагууд нь хүүхдэд ээлтэй, гэр бүлийг дэмжсэн үйлчилгээг нэвтрүүлнэ" хэмээн заасны дагуу хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрууд нь хүүхэд түр саатуулах булан, тоглоомын талбай, хүүхдийн нас биений онцлогт тохирсон ширээ, сандал, ариун цэврийн өрөө бий болгон, хүүхдийн бие физиологийн онцлогт тохирсон хоолны цэс, жор, технологийг баталж мөрдөн хүүхдэд ээлтэй, гэр бүлийг дэмжсэн үйлчилгээг нэвтрүүлж, ажиллах талаарх 08/508 дугаар албан бичгийг аж ахуйн нэгжүүдэд хүргүүлж байна. Мөн архи согтууруулах ундааны аттестатчиллын шалгалтын хүрээнд шалгалтанд хамрагдсан 48 аж ахуйн нэгжид үүрэг чиглэл өгч, хийж хэрэгжүүлсэн ажлын илтгэх хуудсыг авч биелэлтийг тооцон ажилласан.

Нийслэлийн Засаг даргын 2019 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн "Иргэдийг болзошгүй эрсдэлд өртөхөөс сэргийлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" 04 дүгээр албан даалгаврын хэрэгжилтийг хангуулах, хоол, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангаж ажиллах талаарх 2019 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн "Зөвлөмж хүргүүлэх тухай" 08/920 дугаар албан бичгийг Боловсролын хэлтэс, хороод болон дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт хүргүүлж, хяналт тавин ажиллаж байна.

Захирааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4393 дугаарт бүртгэгдсэн Нийслэлийн Засаг даргын 2019 оны 05 дугаар сарын 28-ны өдрийн "Цагийн хязгаар тогтоох тухай" А/504 дүгээр захирамжийг МХХ, Цагдаагийн 1,2-р хэлтэс, хороодын Засаг дарга, архи, согтууруулах ундаа худалдаалдаг болон түүгээр үйлчилдэг 650 гаруй ААНБ-дад хүргүүлж, Цагдаагийн 1-р хэлтэстэй хамтран хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж 4 зөрчил илэрснийг холбогдох арга хэмжээ авч ажилласан. Мөн дүүрэг, хорооны цахим сайт, фэйсбүүк хуудас, мэдээллийн самбарт байршуулан иргэн, аж ахуйн нэгжид мэдээ, мэдээлэл өгч ажиллаж байна.

Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын улсын байцаагчийн 2014 оны 01-01/05, 2016 оны 01-01/08, 2019 оны 02/01/03, 02-01/04-р шийдвэрээр ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгад худалдаа, үйлчилгээ явуулж буй газруудад Нийслэлийн Засаг даргын "Ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны барилгыг дахин төлөвлөж барилгажуулах тухай" захирамжийг 24 иргэн, аж ахуйн нэгжид танилцуулж, ашиглалтын шаардлага хангахгүй орон сууцны судалгааг "Нийслэлийн хот байгуулалт, хөгжлийн газарт" хүргүүлсэн.



Засгийн газрын 2016 оны 202, НИТХ-ын Тэргүүлэгчдийн 2014 оны 221 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Улсын аварга фермер шагналд -1 /Шувууны аж ахуй/, Улсын аварга тариаланч хамт олон шагналд -1/Хүлэмжийн аж ахуй/, Нийслэлийн тэргүүний фермерт-4 нийт 2 аж ахуйн нэгж, 4 иргэнийг шагнуулахаар дүүргийн ИТХ-ын тэргүүлэгчдийн хурлаар дэмжүүлэн материалыг хүргүүлснээс "Улсын аварга фермер"-ээр "Угтуул алтай ХХК", "Нийслэлийн тэргүүний фермер"-ээр дүүргийн 12 дугаар хорооны фермер С.Сонгууль, Н.Баттөр, 13 дугаар хорооны фермер Ч.Зулжаргал нар шалгарч шагналаа гардан авсан.



Мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүсээс зөвшөөрсөн бүс нутагт нүүлгэн шилжүүлсэн мал бүхий өрхүүдийн өвөлжилтийн нөхцөл байдал хүндэрч өвс, тэжээлийн дэмжлэг хүссэний хүрээнд :

- Нүүлгэн шилжүүлсэн 30 өрхөд- 600 боодол
- Дүүргийн 12,13,14 дүгээр хорооны малчид фермерүүдэд -587 боодол өвсийг тус тус хуваарилан олгосон.

Дүүргийн Засаг даргын 2019 оны А/120 дугаар захирамжаар батлагдсан ажлын хэсэг хориглосон бүс дэх малтай өрхийн малыг нүүлгэн шилжүүлэх, хориглосон байршилд мал, амьтан оруулахгүй байх зорилгоор нийт 8 удаа хуралдаж, холбогдох хэлтэс, алба, мал бүхий хороодын Засаг дарга нарт үүрэг даалгавар өгч, 60 өрхөд нүүлгэн шилжүүлэх зардал тус бүр 200000 төгрөг нийт 12,0 сая төгрөг, ажил зохион байгуулах зардалд 2,9 нийт 14,9 сая төгрөгийг дүүргийн Засаг даргын нөөц хөрөнгөөс баталж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажилласан.



Мал нүүлгэн шилжүүлэх ажилд дүүргийн ЗДТГ, Цагдаагийн 2 дугаар хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Мэргэжлийн хяналтын хэлтэс, мал бүхий хорооны нийт 54 ажилтан, албан хаагч ажилласан.

2018 оны жилийн эцсийн мал тооллогын дүнгээр мал аж ахуй эрхлэхийг хориглосон бүс буюу 12 дугаар хороонд 60 өрхийн 1337 малаа тоолуулаагүй 1 өрхийн 4 нийт 61 өрхийн 1341 малаас 59 өрхийн 1297 малыг зөвшөөрсөн бүс нутагт нүүлгэн шилжүүлсэн. Нүүлгэн шилжүүлэлт 96%-тай явагдаж дууссан.



Дүүргийн хүнсээр хангах албаны гамшгийн төлөвлөгөөг боловсруулж батлуулан, хүнс нийлүүлэх 17 мэргэжлийн анги бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ байгуулж, гамшгаас хамгаалах иж бүрэн сургуулиалтын хүрээнд иргэдийг нүүлгэн шилжүүлэх талбайд гал тогоо, худалдаа үйлчилгээ, үс түгээх төвийг тохижуулан 500 иргэнийг хүнсээр, 100 ажилтан албан хаагчдыг халуун хоол, нийт 600 хүнийг хоол хүнсээр ханган ажилласан.



Дүүргийн хэмжээнд 12 хорооны 15 хүнсний дэлгүүр нөөцийн мах худалдан борлуулах гэрээ байгуулан, 30,9 тн махыг хэрэглэгчдэд нийлүүлэх ажлыг зохион байгуулж

ажилласан. Мөн нөөцийн махны өргөтгөсөн худалдааг "Сүхбаатар мах маркет" ХХК-тай хамтран 2 байршил буюу дүүргийн 16 дугаар хороо Буянт Ухаа 1 хорооллын баруун талд, 7 дугаар хороо Ярмагийн хуучин эцэст зохион байгуулан нийт 8,3 тн мах худалдан борлуулсан.

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ХЭМЖЭЭНД НӨӨЦИЙН МАХ ЗАРЖ БҮЙ АЖ АХУЙН НЭГЖЛЭЙН МЭДЭЭЛЭЛ

№	Хүн	Хүн	Хүн
1	Хүн	Хүн	Хүн
2	Хүн	Хүн	Хүн
3	Хүн	Хүн	Хүн
4	Хүн	Хүн	Хүн
5	Хүн	Хүн	Хүн
6	Хүн	Хүн	Хүн
7	Хүн	Хүн	Хүн
8	Хүн	Хүн	Хүн
9	Хүн	Хүн	Хүн
10	Хүн	Хүн	Хүн
11	Хүн	Хүн	Хүн
12	Хүн	Хүн	Хүн
13	Хүн	Хүн	Хүн
14	Хүн	Хүн	Хүн
15	Хүн	Хүн	Хүн
16	Хүн	Хүн	Хүн
17	Хүн	Хүн	Хүн
18	Хүн	Хүн	Хүн
19	Хүн	Хүн	Хүн
20	Хүн	Хүн	Хүн
21	Хүн	Хүн	Хүн
22	Хүн	Хүн	Хүн
23	Хүн	Хүн	Хүн
24	Хүн	Хүн	Хүн
25	Хүн	Хүн	Хүн
26	Хүн	Хүн	Хүн
27	Хүн	Хүн	Хүн
28	Хүн	Хүн	Хүн
29	Хүн	Хүн	Хүн
30	Хүн	Хүн	Хүн
31	Хүн	Хүн	Хүн
32	Хүн	Хүн	Хүн
33	Хүн	Хүн	Хүн
34	Хүн	Хүн	Хүн
35	Хүн	Хүн	Хүн
36	Хүн	Хүн	Хүн
37	Хүн	Хүн	Хүн
38	Хүн	Хүн	Хүн
39	Хүн	Хүн	Хүн
40	Хүн	Хүн	Хүн
41	Хүн	Хүн	Хүн
42	Хүн	Хүн	Хүн
43	Хүн	Хүн	Хүн
44	Хүн	Хүн	Хүн
45	Хүн	Хүн	Хүн
46	Хүн	Хүн	Хүн
47	Хүн	Хүн	Хүн
48	Хүн	Хүн	Хүн
49	Хүн	Хүн	Хүн
50	Хүн	Хүн	Хүн
51	Хүн	Хүн	Хүн
52	Хүн	Хүн	Хүн
53	Хүн	Хүн	Хүн
54	Хүн	Хүн	Хүн
55	Хүн	Хүн	Хүн
56	Хүн	Хүн	Хүн
57	Хүн	Хүн	Хүн
58	Хүн	Хүн	Хүн
59	Хүн	Хүн	Хүн
60	Хүн	Хүн	Хүн
61	Хүн	Хүн	Хүн
62	Хүн	Хүн	Хүн
63	Хүн	Хүн	Хүн
64	Хүн	Хүн	Хүн
65	Хүн	Хүн	Хүн
66	Хүн	Хүн	Хүн
67	Хүн	Хүн	Хүн
68	Хүн	Хүн	Хүн
69	Хүн	Хүн	Хүн
70	Хүн	Хүн	Хүн
71	Хүн	Хүн	Хүн
72	Хүн	Хүн	Хүн
73	Хүн	Хүн	Хүн
74	Хүн	Хүн	Хүн
75	Хүн	Хүн	Хүн
76	Хүн	Хүн	Хүн
77	Хүн	Хүн	Хүн
78	Хүн	Хүн	Хүн
79	Хүн	Хүн	Хүн
80	Хүн	Хүн	Хүн
81	Хүн	Хүн	Хүн
82	Хүн	Хүн	Хүн
83	Хүн	Хүн	Хүн
84	Хүн	Хүн	Хүн
85	Хүн	Хүн	Хүн
86	Хүн	Хүн	Хүн
87	Хүн	Хүн	Хүн
88	Хүн	Хүн	Хүн
89	Хүн	Хүн	Хүн
90	Хүн	Хүн	Хүн
91	Хүн	Хүн	Хүн
92	Хүн	Хүн	Хүн
93	Хүн	Хүн	Хүн
94	Хүн	Хүн	Хүн
95	Хүн	Хүн	Хүн
96	Хүн	Хүн	Хүн
97	Хүн	Хүн	Хүн
98	Хүн	Хүн	Хүн
99	Хүн	Хүн	Хүн
100	Хүн	Хүн	Хүн



Дүүргийн 14 дүгээр хороо барилгын 2-27 тоотод гахайн мялзан өвчин оношлогдсон нь лабораторийн шинжилгээгээр батлагдсантай холбогдуулан Засаг даргын 2019 оны А/122 дугаар захирамжаар өвчин гарсан цэгт хорио цээрийн дэглэм тогтоож, 11 ажилтан албан хаагч 24 цагийн хяналт тавин ажиллаж, нийт 45 гахайг устгаж булшлан, 41500м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн. Ариутгалт 167 тн хлорын шохой, 37,6 тн хайкоф, 3,3 тн суперкил бодис зарцуулсан.

Дүүргийн хэмжээнд гахайн аж ахуй эрхэлж буй 1 аж ахуйн нэгж, 17 иргэний 3302 гахайн судалгааг шинэчлэн гаргаж, мал эмнэлэг үржлийн нэгжүүд тандалт судалгаа хийж, сэрэмжлүүлэг зөвлөмжийг хүргүүлж ажилласан.



Дүүргийн хэмжээнд малын сэг зэм устгалын ажлыг Мал эмнэлгийн тасаг, Тохижилт үйлчилгээний төв, мал бүхий хороодын ажилтан албан хаагчидтай хамтран 2019 оны 04 дүгээр сарын 18-20-ны өдрүүдэд зохион байгуулж, 12, 13,14 дүгээр хорооны 85 ширхэг мал, амьтны сэг зэмийг зориулалтын цэгт устгаж булшлан, 2200м2 талбайд ариутгал халдваргүйжүүлэлт хийсэн.



Газар тариалан эрхэлдэг 26 аж ахуйн нэгж, 420 иргэний мэдээлэл судалгааг шинэчлэн, тариалалтад дэмжлэг үзүүлэн шар лууван 30кг, хүрэн манжин 15кг, шар манжин 5кг, ногоон сонгино 2кг нийт 52 кг хүнсний ногооны үрийг 4,5,6,7,8,9,10,11,12,13,14 дүгээр хороодор дамжуулан 200 гаруй ногоочдод олгож тариалалтыг дэмжин ажилласан. "Монгол

ногоо" төсөлтэй хамтран "Хүлэмжинд хүнсний ногоо тарихын ач холбогдол, хүлэмжийн хөрс боловсруулалт" сэдэвт онол дадлагын сургалт зохион байгуулж, 41 иргэнийг хамруулж 6 төрлийн хүнсний ногооны үр олгосон.

Дүүргийн гэр хороолол бүхий 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16 дугаар хорооны нийт 600 иргэнээс ундны усанд хэрэглэж буй зориулалтын бус хуванцар савны хэрэглээний талаар санал асуулга авч, хуванцар савны хэрэглээг бууруулах, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулан 2 удаа сургалт зохион байгуулж 200 гаруй иргэн хамрагдсан. Мөн "Хуванцар савнаас татгалзъя" гарын авлагыг бэлтгэж, хороодоор дамжуулан 1200 ширхэгийг иргэдэд тараасан.



"Худалдаа, хоол үйлдвэрлэл-2020" нийслэлийн дэд хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/220 дугаар тушаалаар батлагдсан "Үйлчилгээний соёл 5S-ийг хэрэгжүүлэгч шилдэг байгууллага" аяныг дүүргийн хэмжээнд зохион байгуулж, нийслэлийн 6 дүүргээс "Алтан жооно" ХХК-ийн Яармаг "Сансар 34" салбар дэд байранд шалгарсан.



Нийслэлийн "Хүн амын ахуйн үйлчилгээ-2020" дэд хөтөлбөрийн хүрээнд нийслэлийн иргэд, олон нийтийн дунд ахуйн үйлчилгээний шинэлэг технологийг сурталчлах аяныг дүүргийн хэмжээнд зохион байгуулсан. Аяны хүрээнд ахуйн үйлчилгээний салбарын өнөөгийн байдал, цаашдын ирээдүй, хууль, тогтоомж, дүрэм журам, стандарт, дэд хөтөлбөр, аяны танилцуулга хийх зорилгоор дүүргийн үсчин гоо засалчдын зөвлөлдөх уулзалт, Дэлхийн тэмцээнд жил бүр улсаа, дүүргээ төлөөлөн оролцдог Мастер салон сургалтын төвийн сургагч багш нар болон албан бус насан туршийн боловсролын төвтэй хамтран өрх толгойлсон 15 эмэгтэйчүүдэд үсчин, гоо засалчдын тэргүүн туршлага сурталчлах, үзүүлэх сургуулийг тус тус зохион байгуулсан. Мөн дүүрэгт ахуйн үйлчилгээний шинэлэг технологийг нэвтрүүлсэн 3 аж ахуйн нэгж, иргэнийг сонгон шалгаруулж өргөмжлөл, мөнгөн шагналаар тус тус шагнаж урамшуулсан ба нийслэлд "Си Эс Эл" ХХК-ий "Shoe's love" хими цэвэрлэгээ, угаалга, гутал засварын газрын хамт олон дэд байр эзэлсэн.



Нийслэлийн Засаг даргын албан даалгаарын хүрээнд:

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2018 оны 12 дугаар сарын 11-ний өдрийн "Гэрээний үлгэрчилсэн загвар батлах тухай" А/326 тоот тушаалын хүрээнд ААНБ-ыг "Тохижилт цэвэрлэгээний гэрээ"-г хороотой шинэчлэн байгуулж, гэрээний 1 дүгээр хавсралтын №1, №2-н дагуу хариуцах орчны 50м хүртэлх нийтийн эзэмшлийн зам, талбайн зураглалыг Тохижилт нийтийн аж ахуйн хэлтсээр баталгаажуулан 600 гаруй ААНБ-тай гэрээ байгуулж, батламж олгон хамтран ажиллаж байна.

ТҮЦ нүүлгэн шилжүүлэх, ил задгай худалдааг цэгцлэх асуудлаар "Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл" 3 удаа хуралдаж дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Мэргэжлийн хяналтын хэлтэс, Газрын алба, Хүнс худалдаа үйлчилгээний хэлтсээс нийт 48 ТҮЦ, 5 сүүдрэвчтэй худалдаа, 4 машинт худалдаанд газар чөлөөлөх талаар шаардах хуудас, мэдэгдэх хуудсыг тус тус хүргүүлсэн,
- "Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл"-ийн гишүүд ТҮЦ эрхлэгчдийг хүлээн авч сонсох ажиллагаа хийсэн.
- Газрын албатай хамтран Буюнт ухаа-2 хорооллын автобусны буудлын 2, Зайсан толгойн дундын зогсоолын 2, нийт 4 ТҮЦ нүүлгэн шилжүүлсэн.



Ажилчны алдар талбай дахь 5 сүүдрэвчтэй худалдаа, Соёлын ордны хойд зогсоол, Зайсангийн тойруу гудамжинд ил задгай худалдаа эрхэлж буй иргэдэд тухай бүр албан шаардлага хүргүүлж үйл ажиллагааг зогсоосон.



Дүүргийн 2 дугаар хороо Жаргалант үйлчилгээний төв дээрх 6 ТҮЦ, 10 дугаар хороо Айцын даваа явах зам дагуу байрласан хуушуурын 4 ТҮЦ, 2 гэр, 4 машинт худалдаа, 11 дүгээр

хорооны Зайсан толгойн дундын зогсоолын 2, дээд тавцангийн ТҮЦ-ийг 2 удаа, нийт 20 зөөврийн байгууламжийг нүүлгэн шилжүүлсэн.

Жаргалант үйлчилгээний төвийн нийтийн эзэмшлийн талбайгаас нүүлгэн шилжүүлсэн ТҮЦ эрхлэгчдэд амьжиргаагаа залгуулах боломжоор ханган Атлантис худалдаа үйлчилгээний төвтэй хамтран 48м2 талбай гаргаж өгсөн.



Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор 2019 оныг “Эх оронч худалдан авалтын жил” болгон зарласантай холбогдуулан уриалга боловсруулж 480 аж ахуйн нэгж байгууллага, хороод, дэргэдэх хэлтэс, албадад хүргүүлж, нийт 298,8 сая төгрөгний үндэсний үйлдвэрийн бараа бүтээгдэхүүн худалдан авсан байна.

2.2 Нийслэлийн Засаг даргаас тухайн жилд хэрэгжүүлэхээр зарласан зорилтот ажлын хүрээнд хийж хэрэгжүүлсэн ажилтай холбоотой мэдээлэл:

ГУРАВДУГААР БҮЛЭГ: “БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН”

3.1 Байгууллагын дүрмээр хүлээсэн үндсэн үүргийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл:


Төсвийн Шууд захирагч, Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулах 2019 оны Үр дүнгийн гэрээний төслийг боловсруулан батлуулсан бөгөөд гэрээний 2 дугаар хавсралт болох “Гүйцэтгэлийн төлөвлөгөө”-нд тусгах саналыг хэлтэс, тасгуудаас хүлээн авч нэгтгэн батлуулсан. Тус төлөвлөгөө нь нийт 6 бүлгээс бүрдэж байгаа бөгөөд “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд 33, “Нийслэлийн дэд хөтөлбөр”-ийн хүрээнд 1, “Дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн хүрээнд 101, “Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил”-ийн хүрээнд 13, Засаг даргын Тамгын газрын дүрмээр хүлээсэн чиг үүргийн хүрээнд 16, бусад ажлын хүрээнд 10, нийт 174 ажлыг хэрэгжүүлж ажиллахаар төлөвлөсөн.

Хүснэгтээр харуулбал:

Д/д	Төлөвлөгөөний бүтэц	Төлөвлөсөн ажил
1	“Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”	33
2	“Нийслэлийн дэд хөтөлбөр”	1
3	“Дүүргийн Засаг даргын 2017-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”	101
4	“Иргэдийн оролцоотой-Хөгжлийн жил”	13
5	Засаг даргын Тамгын газрын дүрмээр хүлээсэн чиг үүрэг	16
6	Бусад ажлын хүрээнд	10

6 бүлгийн хүрээнд 174 ажил

Графикаар харуулбал:



2019 оны эхний хагас жилийн байдлаар төлөвлөгөөний биелэлт 54 хувьтай, жилийн эцсийн биелэлт 87%-тай тус тус хэрэгжсэн.

Монгол Улсын Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2019 оны 47 дугаар тушаалаар Байгууллага, нэгж, төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж, тайлагнах журам, аргачлалыг баталсан. Дээрх журмын дагуу Засаг даргын Тамгын газрын хоёрдугаар хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 87 зорилтын хүрээнд 108 ажил үйлчилгээг хийж гүйцэтгэхээр төлөвлөсөн.

Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилт:

Нийслэл, дүүргийн нутгийн захиргааны байгууллагын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн: Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн 2019 онд нийт 23 удаа зохион байгуулагдан 212 үүрэг даалгавар өгөгдөн 83.2%-тай хэрэгжсэн бөгөөд 8 үүрэг даалгавар хэрэгжих шатандаа байна.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд мэдээлдэг дүүргийн 14 хоногийн Гэмт хэрэг, зам тээврийн осол, аваарын нөхцөл байдал, Онцгой комиссын мэдээлэл, Газрын харилцааны зөрчил, Хөрөнгө оруулалтын ажлын явц, үр дүнгийн талаарх мэдээллийг холбогдох хэлтэс, албадаас хүлээн авч нэгтгэн ажилласан.

Дүүргийн нутгийн захиргааны байгууллагуудын удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг журмын дагуу нийт 13 удаа зохион байгуулсан. Шуурхай зөвлөгөөнөөс дүүргийн Засаг дарга нийт 123 үүрэг даалгавар өгч, 77.8-тай хэрэгжин, 14 үүрэг даалгавар хэрэгжих шатандаа байна. Үүрэг даалгавар болон биелэлтийг <http://www.khanuul.mn/> сайтад тухай бүр байршуулж байна.

Засаг даргын зөвлөлийн хурал: Засаг даргын Зөвлөлийн хурал 2019 онд 21 удаа хуралдаж дүүргийн "Ахмадаа дээдэлье", "Зөв хүүхэд-Зөв ирээдүй", "Аз жаргалтай гэр бүл", "Хорооны хөгжил-Төрийн үйлчилгээ" хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхтэй холбогдсон арга хэмжээ зохион байгуулах, иргэдийн санал бодолд тулгуурлан шийдвэрлэх асуудал, цаг үеийн тулгамдсан ажлууд зэрэг 134 асуудлыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөн: Засаг даргын Тамгын газрын даргын шуурхай зөвлөгөөнийг хагас жилийн хугацаанд 22 удаа зохион байгуулж, 183 үүрэг даалгавар өгөгдөн 81 хувийн биелэлттэй хэрэгжсэн байна.

Шагнал урамшууллын талаар: 2019 оны жилийн эцсийн байдлаар дүүргийн Засаг даргын 6 удаагийн захирамжаар дүүргийн Засаг даргын шагнал "Хүндэт тэмдэг"-ээр 30, "Жуух бичиг"-ээр 147, "Өргөмжлөл"-өөр 133 нийт 310 иргэн тус тус шагнагдсан.

Засаг даргын албан бичгээр Засгийн газар болон Яамны шагналаар шагнуулахаар Эрүүл мэндийн яаманд 10, Зам, тээвэр хөгжлийн яаманд 25, Хүнс, хөдөө аж ахуйн яаманд 187, Сангийн яаманд 15 нийт 237 иргэний материалыг дэмжин уламжилж хүргүүлсэн.



Тамгын газрын тайлангийн хурал:

Засаг даргын Тамгын газрын албан хаагчдын эхний хагас жилийн тайлангийн хурлыг 2019 оны 06 дугаар сарын 18-ны өдөр, жилийн эцсийн тайлангийн хурлыг 12 дугаар сарын 20-ны өдөр тус тус зохион байгуулж, хурлаар хэлтэс, тасгуудын 2019 оны үйл ажиллагааны тайланг сонсч, Засаг дарга, Тамгын газрын дарга 2019 онд хийсэн ажлын алдаа, оноог дүгнэн үг хэлсэн. Зөвлөгөөнд 9 хэлтэс, тасгийн нийт 80 албан хаагч оролцсон.



Гадаад харилцааны чиглэлээр:

ХАН-УУЛ ДҮҮРЭГ БОЛОН БНХАУ-ЫН ӨМӨЗО ГАДААД ХАРИЛЦААНЫ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр БНХАУ-ын ӨМӨЗО-ны Эрээн хот болон бусад хотуудын Гадаад харилцаа хариуцсан дарга нар Хан-Уул дүүрэгт айлчлал хийсэн.



Уулзалтын үеэр Хан-Уул дүүргийн Засаг даргын орлогч А.Амартүвшин хоёр талын хамтын ажиллагааг эрчимжүүлж, бизнесийн чиглэлээр түлхүү хамтран ажиллах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн. 2019 оны 08 дугаар сард БНХАУ-ын ӨМӨЗО-д зохион байгуулагдах ОУ-ын үйлдвэрлэл, үйлчилгээний үзэсгэлэн худалдаанд Хан-Уул дүүргийн үндэсний үйлдвэрлэл эрхлэгч нарыг оролцуулах тухай санал тавьж, харилцан дэмжин ажиллах талаар харилцан санал солилцсон.

ХАН-УУЛ ДҮҮРЭГ БОЛОН БНСУ-ЫН ХАМАН СУМЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

БНСУ-ын Гёнгсан аймгийн Хаман сумын ИТХ-ын дарга Паг Юун Сун, Засаг дарга Жу Гын Жэ тэргүүтэй тус сумын ИТХ-ын төлөөлөгчид 07 дугаар сарын 10-13-ны өдрүүдэд Хан-Уул дүүрэгт албан айлчлал хийсэн. Хан-Уул дүүрэг болон Хаман сумын хамтын ажиллагааны хүрээнд Хаман сум буцалтгүй тусламж буюу 100%-ийн хөрөнгө оруулалттайгаар Хан-Уул дүүргийн 13 дугаар хороонд байрлах "Хан-Уул Агро" парсад 50




метр урттай 4 улирлын зориулалттай 8 ширхэг тарвасны хүлэмжийг бэлэглэж, 04 дүгээр сард Хаман сумын мэргэжлийн баг хамт олон "Хан-Уул Агро" паркад ажиллаж эхэлсэн.

Айлчлалын хүрээнд тус хүлэмжүүд нээлтээ хийсэн бөгөөд нээлтийн үйл ажиллагаанд хоёр талын тэргүүлэгчид буюу НИТХ-ын төлөөлөгч, Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан, ИТХ-ын дарга Б.Цэрэн нар оролцож, цаашдаа хоёр улсын хамтын ажиллагааны цар хүрээгээ улам тэлж, нягт хамтран ажиллахаар болсон.



ХАН-УУЛ ДҮҮРЭГ БОЛОН БНСУ-ЫН УЛСАН ХОТЫН НАМ ДҮҮРГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

Хан-Уул дүүргийн урилгаар БНСУ-ын Улсан хотын Нам дүүргийн Засаг дарга Ким Жин Гю, Нам дүүргийн ИТХ-ын дарга Ким Дун Хаг тэргүүтэй төлөөлөгчид 2019 оны 07 дугаар сарын 10-13-ны хооронд Хан-Уул дүүрэгт албан айлчлал хийсэн. Айлчлалын хүрээнд Хан-Уул дүүрэг, БНСУ-ын Улсан хотын Нам дүүрэгтэй хамтын ажиллагааны санамж бичиг байгуулсан бөгөөд санамж бичгийг НИТХ-ын төлөөлөгч, Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан, БНСУ-ын Улсан хотын Нам дүүргийн Засаг дарга Ким Жин Гю, Хан-Уул дүүргийн ИТХ-ын дарга Б.Цэрэн, Нам дүүргийн ИТХ-ын дарга Ким Дун Хаг нар



үзэглэсэн.



Хамтын ажиллагааны санамж бичгийн зорилго нь Монгол-Солонгос хоёр улсын ард иргэдийн хоорондын харилцаа холбоо болон дүүргүүдийн найрсаг харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх оршино.

ЯПОН УЛСЫН МУСАШИМУРАЯАМА ХОТЫН СУРАГЧ ХҮҮХДҮҮДИЙГ ХҮЛЭЭН АВСАН ТУХАЙ:

Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан Япон Улсын Мусашимураяама хотын дарга Фужино Масару тэргүүтэй төлөөлөгчдийг 2019 оны 07 дугаар сарын 10-ны өдөр хүлээн авч, санамж бичиг байгуулсан.

Санамж бичгийн хүрээнд хоёр дүүрэг сурагч солилцооны хөтөлбөрийг эхлүүлж эхний байдлаар Хан-Уул дүүргийн ерөнхий боловсролын 4-6 дугаар ангийн 5 хүүхдүүдийг үндсэн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу сонгон шалгаруулж, Мусашимураяама хотод зохион байгуулагдах соёл, урлаг, спортын арга хэмжээнд оролцуулахаар боллоо. Сонгон шалгаруулалтад нийслэл, дүүрэгт урлаг, спортоороо бусдыгаа тэргүүлдэг сурагчид шалгарсан бөгөөд тус хотын соёл, урлагийн арга хэмжээнд Хан-Уул дүүргийн авьяаслаг хүүхдүүдийг төлөөлөн оролцох юм.



2019 оны 07 дугаар сарын 31-ний өдрөөс 08 дугаар сарын 05-ны өдрүүдэд Япон Улсын Мусашимураяама хотын арван сурагч, таван багш хүмүүжүүлэгчдийг хүлээн авах ажлыг зохион байгуулж, соёл урлаг, спортын арга хэмжээнд оролцох 10 сурагчийг Хан-Уул дүүргийн Засаг даргын орлогч А.Амартүвшин хүлээн авч уулзсан.

ХАН-УУЛ ДҮҮРЭГ БОЛОН БНСУ-ЫН МЁНЖИ ЭМНЭЛГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ХҮРЭЭНД:

Бүгд Найрамдах Солонгос улсын Гу-Яан хотын Дог-Яан дүүргийн эмч, төлөөлөгчдийг 2019 оны 09 дүгээр сарын 29-ны өдрөөс 10 дугаар сарын 02-ны өдрүүдэд хүлээн авах ажлыг зохион байгуулсан.

Тус эмнэлгийн Монгол Улсад ирсэн зорилго нь Хан-Уул дүүрэгтэй хамтран ажиллах талаар санамж бичиг үйлдэх мөн дүүргийн Эрүүл Мэндийн төвд "Сайн үйлсийн аян"-г хэрэгжүүлэх юм. Хан-Уул дүүргийн иргэдэд шаардлагатай эрүүл мэндийн үзлэг, оношлогоог хийж, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эмнэлгийн цогц үйлчилгээг шат дараатай хийхээр болсон.

Түүнчлэн "Мёнжи" эмнэлгийн "Сайн үйлсийн аян"-ы хүрээнд "Дотрын тасаг" болон "Хөх, бамбай мэс заслын тасаг"-ын мэргэжлийн эмч, мэргэжилтнүүд Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв дээр хоёр өдрийн турш дүүргийн 300 гаруй иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгч, эмчилгээ, оношлогоо хийж ажилласан. Цаашид Хан-Уул дүүрэг тус эмнэлэгтэй эрүүл мэндийн чиглэлээр илүү нягт холбоотой үр дүнтэй хамтран ажиллахаар болсон.




Гадаад томилолт:

ЯПОН УЛСЫН МУСАШИМУРАЯАМА ХОТЫН АЙЛЧИЛСАН ТУХАЙ:

Япон Улсын Мусашимураяама хотод НИТХ-ын төлөөлөгч, Хан-Уул дүүргийн Засаг дарга болон холбогдох албаны төлөөлөгчид 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдрөөс 03 дугаар сарын 02-ны

өдрүүдэд айлчлан хоёр талын хамтын ажиллагаа, цаашид хэрэгжүүлэх ажлуудын талаар хэлэлцсэн.



КВЕБЕК МУЖИЙН ГАТИНО ХОТОД АЙЛЧИЛСАН АЖЛЫН ТАЛААР:

Хан-Уул дүүргийн Засаг дарга бөгөөд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгч Ж.Алдаржавхлан тэргүүтэй төлөөлөгчид Гатино хотод зочилж, хотын Захирагч Максим Педно-Жобинтой уулзан хамтран ажиллах боломжийн талаар санал солилцсон.



БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛСАД АЙЛЧИЛСАН ТУХАЙ

Нийслэлийн Хан-Уул дүүргийн ЗДТГ-ын төлөөлөгчид 2019 оны 05 дугаар 12-16-ны



өдрүүдэд БНПУ-д ажлын айлчлал хийн Доод Селесин мужийн Зубкович дүүргийн газар тариалангийн компаниудын үйл ажиллагаатай танилцан Жолли үйлдвэрийн удирдлагуудтай хамтран ажиллахаар болсон. Мөн Зубкович дүүргийн удирдлагуудтай уулзан хоёр дүүргийн хамтын ажиллагааг газар тариалан, мал аж ахуй, оюутан солилцооны чиглэлээр байгуулах талаар санал бодлоо солилцон хамтран ажиллах хүсэлтийг хүлээн авч

хамтран ажиллахад бэлэн байгаагаа илэрхийлсэн.

БҮГД НАЙРАМДАХ БОЛГАР УЛСАД АЙЛЧИЛСАН ТУХАЙ

НИТХ-ын төлөөлөгч, Хан-Уул дүүргийн Засаг дарга Ж.Алдаржавхлан болон холбогдох албаныхан 2019 оны 06 дугаар сарын 21-25-ны өдрүүдэд Бүгд Нариймдах Болгар Улсын Софи хотод айлчлан хоёр талын хамтын ажиллагаа, цаашид хэрэгжүүлэх ажлуудын талаар хэлэлцсэн. Айлчлалын үеэр боловсрол, соёл урлаг, спорт зэрэг чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх, цаашид хоёр тал 2020 онд хэрэгжүүлэх дээрх чиглэлээр хамтран ажиллах ажлын талаар санал солилцсон.



Япон улсын Токио хот, БНСУ-ын Гёнг-Сан аймгийн Хаман сум, Улсан хотын Нам дүүрэг, Чиньжү хот, Ханой хотын "Төрийн захиргааны байгууллагын туршлага-арга зүй" сургалтуудад тус тус Хан-Уул дүүргийн нийт 26 албан хаагч мэргэжил арга зүйн туршлага



судалсан.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН ЧИГЛЭЛЭЭР:

ТОХИЖИЛТ НОГООН БАЙГУУЛАМЖИЙН ЧИГЛЭЛЭЭР:

БАТЛАН ХАМГААЛАХЫН ЧИГЛЭЛЭЭР:

3.2 Хүний нөөцийг чадавхжуулах, тогтвор суурьшилтай ажиллуулах талаар байгууллагын тухайн жилийн төлөвлөгөөнд тусгасан зорилтын хэрэгжилттэй холбоотой мэдээлэл:

3.3 Иргэдээс ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой мэдээлэл:

3.4 Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой мэдээлэл:

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ

4.1 Байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн хэрэгжилттэй холбоотой мэдээлэл:

ТАВДУГААР БҮЛЭГ: “БУСАД МЭДЭЭЛЭЛ”

5.1 Холбогдох чиг үүргийн дагуу нутгийн захиргааны бусад байгууллагатай ажлын уялдаа холбоог хангах чиглэлээр хамтран ажилласан тухай мэдээлэл:

Хяналт, шалгалт: Дүүргийн нутаг дэвсгэрт худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй иргэн, ААНБ-д хүнсний аюулгүй байдал болон холбогдох хууль, тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах үүднээс МХХ, ЦХ, НЗАА зэрэг холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран нийт 11 удаагийн хяналт шалгалт зохион байгуулж 577 иргэн аж ахуйн нэгжийг хамруулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

№	Салбар	Хяналт, шалгалтын тоо	Хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо
1	Худалдаа үйлчилгээ	4	316
2	Хоол үйлдвэрлэл	3	211
3	Аялал жуулчлал	1	4
4	Ахуйн үйлчилгээ	-	-
5	Авто засвар, үйлчилгээ	2	34

6	ЖДҮ	1	12
	НИЙТ	11	577

Монгол улсад "Африкийн гахайн мялзан" өвчин илэрсэнтэй холбоотой Нийслэлийн Засаг даргын 2019 оны 01 дүгээр сарын 13-ны А/20 дугаар захирамж, УБХЕМ-ийн тушаалаар нийслэлийн хэмжээнд 72 цагийн онц байдал зарлаж дүүрэг тус бүрт 7 хүний бүрэлдэхүүнтэй 3 ажлын хэсэг гарч худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлдвэрийн газруудаар хяналт шалгалт хийж, гахайн мах, махан бүтэгдэхүүнийг битүүмжлэн лацдах ажил хийгдэж байна.

22 үйлдвэрт хяналт шалгалт хийж,

- Гахайн өөх - 220,4 кг
- Гахайн хуйх 14 кг
- Гахайн махан боловсруулсан бүтээгдэхүүн 924 кг
- Гахайн мах 615 кг тус тус битүүмжилж, зөвлөмж өгсөн.

67 хоол үйлдвэрлэлийн газарт хяналт шалгалт хийж,

- 36 газрын 576,975 кг мах битүүмжилсэн.

44 худалдааны газарт хяналт шалгалт хийж,

- 17 нэр төрлийн 1205,6 кг 13.6 сая төгрөгийн бүтээгдэхүүн битүүмжилсэн.

НИЙТ – 133 газарт хяналт тавьж 3 тн 555,9 кг мах битүүмжилж, цаг тухайд нь мэдээгээ өгч ажилласан.



"Согтууруулах ундаа худалдах болон түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй газруудад аттестатчиллын шалгалт явуулах тухай" А/76 дугаар тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу 04 дүгээр сарын 01-ний өдрөөс 05 дугаар сарын 22-ны хооронд багтаан 16 хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний цэг салбарт явуулсан.

Аттестатчиллын шалгалтанд нийт 285 аж ахуйн нэгж хамрагдахаас:

- Худалдааны 202 газраас 177 газар
- Хоол үйлдвэрлэлийн 83 газраас 74, нийт 251 газар тус тус хамрагдсан.



Монгол улсын шадар барилга байгууламжинд аюулгүй байдлын тухай, бичгийн хэрэгжилтийг прокурорын газар, зохион байгуулсан.



сайдын баталсан "Үйлдвэрийн гамшгаас хамгаалах болон галын стандарт, норм, нормативын баримт хангуулах" хяналт шалгалтыг онцгой байдлын хэлтэстэй хамтран



Авто үйлчилгээ эрхлэгчдийн албан хаагчдын судалгаа мөн цаашид шаардлагатай байгаа хүний нөөцийн асуудлаар хийсэн хяналт шалгалтыг зохион байгуулсан.

УБ хотын Ерөнхий менежерийн 2019 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн "Автомашинь засвар, үйлчилгээний газруудад үзлэг, шалгалт зохион байгуулах тухай" А/175 дугаар тушаалын хүрээнд Дүүрэг дэх Мэргэжлийн хяналтын хэлтэс, Онцгой байдлын хэлтэс, Цагдаагийн хэлтэстэй хамтран автомашинь засвар, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй 22 иргэн, аж ахуйн нэгжид хяналт шалгалт хийж, холбогдох үүрэг чиглэл өгсөн. Дүүрэг дэх Онцгой байдлын хэлтсийн мэргэжилтэн гал түймрийн хяналтын улсын байцаагч а/д Ц.Барсхүү дүүргийн нутаг дэвсгэрт байрлах авто үйлчилгээний барилга байгууламж, объектуудад галын аюулгүй байдлыг хангах шалгалтыг хийж нийт гал түймэр гарч болзошгүй 54 зөрчил илрүүлж, шалгалт хийх явцад болон газар дээр нь 6 зөрчлийг засуулж албан шаардлага хүргүүлэн галын аюулгүй байдлаа хангаж ажиллаагүй 2 иргэнийг зөрчлийн тухай хуулийн дагуу 600,000 төгрөгийн арга хэмжээ авч ажилласан.



Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын 2019 оны 10 дугаар 15-ны өдрийн "Хяналт шалгалт явуулах тухай" удирдамжийн хүрээнд дүүргийн "Орон сууцны болон үйлчилгээний зориулалттай өндөр барилга байгууламжууд, барилгын нэг болон зоорийн давхрын баар, караоке, ресторанд ОБХ, МХХ, Цагдаагийн 1, 2 дугаар хэлтэстэй хамтран шөнийн хяналт, шалгалтын ажлыг зохион байгууллаа. Шалгалтанд нийт 61 аж ахуйн нэгж хамрагдаж, 19 субъектэд 9 сая төгрөгийн торгууль ноогдуулан холбогдох арга хэмжээг авч, зөрчлийг арилган ажиллаа.



Дүүргийн Боловсролын хэлтэстэй хамтран “Эко дүүрэг-Эко хоол хүнс” уралдааныг төрийн өмчийн цэцэрлэгийн тогооч нарын дунд зохион байгуулсан ба уралдаанд төрийн өмчийн 29 цэцэрлэгийн тогооч нар амжилттай оролцож, 1-р байр 250 дугаар цэцэрлэг тогооч Н.Баттулга, 2-р байр 73 дугаар цэцэрлэг тогооч Б.Маржаачун, 3-р байр Хүүхдийн клиник сувилал тогооч Ү.Мөнхгэрэл, тусгай байрт 28 дугаар цэцэрлэг тогооч Л.Мөнхжаргал, 29 дүгээр цэцэрлэг тогооч Ш.Доржханд нар тус тус шалгарсан.



Махны өргөтгөсөн худалдааг тус дүүргийн 2 дугаар хороо “Лавай”, 4 дүгээр хороо “Фермерүүд” худалдааны төвд зохион байгуулж, Баянхонгор – 238, Хөвсгөл – 2300, Өмнөговь – 131 нийт 2669 ширхэг гулууз буюу нийт 55.5 тн мах зарагдсан. Махны худалдаанд мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангуулах, худалдах, борлуулах үеийн хяналтыг тавьж ажилласан.



Дүүргийн 12, 13, 14 дүгээр хорооны нутаг дэвсгэр дэх саалийн үнээний аж ахуйн үржүүлэгт ашиглаж буй буханд ангилалт хийх ажлыг Нийслэлийн Хүнс, хөдөө аж ахуйн газар, “Шилмэл мал сүрэг” хоршоотой хамтран хийсэн

5.2 Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, хүсэлтийн дагуу зохион байгуулсан үйл ажиллагааны талаарх мэдээлэл:

10-р хороо “Буянт-Ухаа” 2 хороололд байрлах “Жимс ногооны дэлгүүр”-т ирүүлсэн өргөдлийг шийдвэрлэн зөрчлийг арилгаж, хамтран ажиллах гэрээ байгуулсан.

ТҮЦ-тэй холбогдолтой 5 өргөдөл хүлээн авч, “Худалдаа үйлчилгээг зохицуулах зөвлөл”-ийн хурлаар хэлэлцүүлж, хяналт шалгалт хийж, албан шаардлага хүргүүлж, иргэнд хариуг өгч ажилласан.

Ерөнхий боловсролын сургуулиас 500 метр дотор тамхи худалдаалж байгаа талаар ирүүлсэн иргэний өргөдлийн дагуу хэмжилт хийн, хариуг хүргүүлсэн.



Засаг даргын Тамгын газрын хэлтэс, тасгуудын сарын аяны хүрээнд болон шинээр санаачлан хэрэгжүүлж буй ажлуудаас:

Сайн үйлсийн аян:

БНСУ-ын Гёнгсан-нам аймгийн Бусан хотын "Хэ-Яан" их сургуулийн багш, төлөөлөгчидтэй хамтран ажиллахаар холбоо тогтоож, 2019 оны 04 сард хүлээн авч уулзан дүүрэгт хэрэгжүүлэх "Сайн дурын үйл ажиллагаа"-ны /тохижилт, ногоон байгууламж хийх / талаар харилцан тохиролцож, 2019 оны 7-р сард "Хэ-Яан" их сургуулийн багш, оюутнуудын төлөөлөл дүүргийн 13-р хорооны 26 дугаар сургуульд "Сайн үйлсийн аян" төслийн ажлыг хэрэгжүүлэхээр боллоо.



Автобустай өртөөчилсөн аялал:

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, хөрөнгө оруулалтын ажлыг сурталчлах зорилгоор "Автобустай өртөөчилсөн аялал"-ыг ХӨХҮХ-тэй хамтран 3 удаа зохион байгуулж 1, 2, 3, 4, 5, 6, 7, 8, 11, 12, 13, 14, 15 дугаар хороодын нийт 135 иргэнийг хамруулж, дүүргийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлуудтай газар дээр нь танилцуулах ажил зохион байгууллаа.



Танилцуулга бэлтгэлээ:

2017, 2018 онд хэрэгжүүлсэн арга хэмжээ болон 2019, 2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж буй төсөл арга хэмжээний мэдээллийг боловсруулан танилцуулга бэлтгэсэн.



Тамгын газрын албан хаагчдын энгэрийн тэмдгийг шинээр хэвлүүлсэн.



- Шинээр томилогдсон албан хаагчдад зориулсан гарын авлага бэлтгэж, хэвлүүлэх ажлыг зохион байгуулан ажилласан.
- Батлагдсан төсвийн дагуу аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан 2019 оны ширээний хуанли хэвлүүлсэн.
- Тохижилт нийтийн аж ахуйн хэлтсээс иргэдэд хог ангилан ялгах, хог хаягдлын тухай хуулийг сурталчилсан таниулах зорилгоор гарын авлага тараах материалыг хэвлүүлсэн.
- Хан-Уул дүүргийн иргэдэд төрийн үйлчилгээг сурталчилсан гарын авлага, цаасан эко тор, бичиг хэргийн сет, тэмдэглэлийн дэвтрийг хэвлүүлсэн.



2019 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Санхүү, төрийн сангийн хэлтсийн сарын аяны хүрээнд " Дөрвөн бэрх" ардын уламжлалт наадмыг амжилттай зохион байгуулж нийт хэлтэс, тасгийн албан хаагчид идэвхи санаачлагатай 100 хувийн ирцтэйгээр /албан ёсны чөлөөтэй/ оролцов.



✚ Эмэгтэй албан хаагчдад зориулан Нүүрний иогын ашиг тус, ач холбогдлыг таниулах сургалтыг ГБХЗХХ-н дарга О.Мягмарсүрэнгэй хамтран зохион байгууллаа. Хүний нүүрэнд нийт 50 гаруй булчин байдаг ба эдгээр булчингаа хэрхэн ажиллуулж хөгшрөлт, арьсны унжилтаас сэргийлэх талаар эмэгтэйчүүдэд үнэтэй зөвлөгөө болсон.



✚ Дүүргийн ЗДТГ-ын хэлтэс, тасгууд хариуцаж авсан хороодтой хамтран ажиллах ажлын хүрээнд СТСХ-ийн хамт олон 3 дугаар хорооны ахмадын байрыг засварлах ажилд идэвхи санаачлагатай оролцлоо.



ГБХЗХХ-ийн дэргэдэх түр хамгаалах байранд шаардлагатай зүйлсийн судалгаа хийж оёдлын машин хандивласан. Үйл ажиллагаанд ХУД-ийн Засаг даргын орлогч А.Амартүвшин, Тамгийн газрын дарга Б.Энхболд, СТСХ-ийн дарга М.Цогзолмаа хэлтсийн албан хаагчдын хамт оролцлоо. Сайн санааны энэхүү аяныг тус хэлтсийн албан хаагчид хуримтлал үүсгэн зохион байгууллаа.



5 дугаар сарын 24-ний өдөр дүүргийн төсөвт байгууллагуудын санхүүгийн ажилтнуудын дунд 4 төрөлт спортын арга хэмжээ зохион байгуулж нийт 120 гаруй ажилтан албан хаагчид хамрагдан ерөнхий боловсролын сургуулиудын нягтлан бодогчдын баг шилжин явах цомын эзнээр шалгарсан.




Бусад ажлын чиглэлээр:

ӨМЧ ХӨРӨНГИЙН БҮРТГЭЛ АШИГЛАЛТ ХАМГААЛАЛТЫН ТАЛААР

Дүүргийн Өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлыг хагас жилийн хугацаанд 4 удаа зохион байгуулж, жилийн ажлын төлөвлөгөөг боловсруулан дараах ажлуудыг хийсэн. Үүнд:

- Дүүргийн төсвийн хөрөнгөөр бий болсон 49,943,800 төгрөгийн хөрөнгийг бүртгэсэн.
- Нийслэлийн өмчийн, ашиглалт удирдлагын газраас ирсэн албан бичгийн дагуу тус дүүргийн 1,2,8,10,11,13,14,15-р хороодын нутаг дэвсгэрт хийгдсэн Нийтийн эзэмшлийн хөрөнгө бүртгэх 3 тушаал боловсруулан батлуулж 536,6214,415 төгрөгийг нийтийн эзэмшлийн хөрөнгөнд бүртгэн авсан.

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ХӨРӨНГӨ



- Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Ахмадын хороо, Худалдан авах ажиллагааны албатай интернет ашиглалтын 8,800,000 төгрөгийн гэрээ, "Блю Марк

Интернешл" ХХК-тай 16 дугаар хороонд байрлах нийтийн халуун усны байр ашиглалтын гэрээг тус тус байгуулсан.

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 273-р тогтоолын дагуу дахин үнэлгээний тооллогыг явуулж, нэгтгэсэн судалгааг гаргаж өгсөн.

5.4 Хөрөнгө санхүүжилтийн асуудлаас бусад үндсэн үйл ажиллагаа явуулахад гарч байгаа хүндрэл, бэрхшээл, болон цаашид авч хэрэгжүүлэх ажлын талаарх мэдээлэл:

Хүндрэлтэй асуудлууд:

1. Хэлтсүүдийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдаагүй, цаг үеийн асуудлаар зохион байгуулах шаардлага гарч буй арга хэмжээнүүд тухайн жилийн батлагдсан төсөвт тусгагдаагүй байдаг тул шийдвэрлэхэд хүндрэлтэй, цаг хугацаа тулсан байдаг.

2. Дээд газруудаас ирж байгаа олон нийтийг хамарсан болон бусад цаг үеийн шинжтэй ажил зохион байгуулах, биелэлт, судалгаа, мэдээлэл авах тухай албан бичгүүдийн хугацаа тулж ирүүлдэг.

Цаашид анхаарах асуудлууд:

1. Зохион байгуулж буй үйл ажиллагааны үр дүн, ач холбогдлын талаар иргэдээс тухай бүр санал асуулга авч, түүний мөрөөр дүн шинжилгээ хийж ажлаа төлөвлөх

2. Олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд Засаг даргын Тамгын газар, дэргэдэх хэлтэс, алба, хороодын албан хаагчид, иргэдийн идэвх оролцоог нэмэгдүүлэх

3. Төлөвлөсөн ажлыг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэл сайтай хийж гүйцэтгэх, үр дүнг тооцож ажиллах

4. Зохион байгуулах үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтмол сурталчилж, олон нийтэд ил тод мэдээлж байх